**ОРХОН АЙМГИЙН
ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА,
ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР**

Уурхайчдын гудамж, Уурхайчин баг,
Баян-Өндөр сум, Орхон аймаг, 61049
Утас/Факс: (976) 7035 2609
Цахим шуудан: orkhon@gazar.gov.mn

2024.12.03 № 857

танай ____________-ны № ____________-т

ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ,
ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ЕРӨНХИЙ
ГАЗАРТ

Байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний бүтэн жилийн биелэлтийг гарган хүргүүлж байна.

Хавсралт...84...хуудастай.

ДАРГА Д.ЦОЛМОН

D: / My documents/ A-5doc

# ОРХОН АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

*Биелэлт хянасан:* **_Төсвийн Ерөнхийлөн захирагч_**

ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА .......................... /А.ЭНХМАНЛАЙ/

*(албан тушаал)* *(гарын үсэг)*

*(огноо)*

*Тэмдэг* ..................................

*Биелэлт гаргасан:* **_Төсвийн Шууд захирагч_**

ОРХОН АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА .......................... /Д.ЦОЛМОН /

*(албан тушаал)* *(гарын үсэг)*

*(огноо)*

*Тэмдэг* 2024.12.03

# 2.1.8ОРХОН АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БҮТЭН ЖИЛИЙН БИЕЛЭЛТ

## НЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хэрэгжилт | Хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Стратеги төлөвлөгөөний зорилго 1.1.**<br>**Улсын хэмжээнд хот суурингийн төвийн 1:1000-ны масштабтай байр зүйн зураг, газар доорх шугам сүлжээний зургийг Дэлхийн геодезийн сүлжээний 2020 эринд шилжүүлэх ажлыг зохион байгуулна.** | | | | | | | |
| **1.1.1** | **Том масштабын байр зүйн тоон зураг, инженерийн шугам сүлжээний зураглал** | **Орон нутгийн төсөв** | **Төсвийн тооцоо-1** | **Засгийн газрын 267-р тогтоол** | **1:1000-ны масштабтай байр зүйн болон инженерийн шугам сүлжээний зураглалыг ITRF2020 эринд шилжүүлэх үндэслэл, хэрэгцээ шаардлага, төсвийн тооцоог гаргаж, 2023 оны төсөвт тусгуулахаар Засаг даргад хүргүүлсэн байна.** | | |
| 1.1.1.1 | Том масштабын байр зүйн зураг, инженерийн шугам сүлжээний зураглалыг шалгаж хүлээн авах | Орон нутгийн төсөв | 2 сумын зураглалын ажлын даалгавар, зураглал | 21 аймаг, 330 сум, 45 суурин газарт зохиогдсон 1:1000-ны масштабтай байр зүйн зургийг 2013-2017 онд зурагласан. | **Эхний хагас жилд:**<br>1:1000-ны масштабтай байр зүйн болон инженерийн шугам сүлжээний зураглалыг ITRF2020 солбицлын тогтолцоонд гүйцэтгэх Ажлын даалгавар хамтран боловсруулж, батлан сумдад хүргүүлсэн байна.<br>**Жилийн эцэст:**<br>1:1000-ны масштабтай байр зүйн болон инженерийн шугам | Орхон аймгийн Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ийн шинэ хаягдлын сангийн 4300 га талбайн том масштабын геодезийн байр зүйн зургийг архивын баримт бичгийн бүрдлийн дагуу хүлээн авч, зураглалын ажлын хүрээнд хийгдсэн шинээр суулгасан геодезийн 28ш цэг тэмдэгтийг БД 11-104-19 стандартын дагуу 2024 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 02/24 дугаартай акт үйлдэн хүлээн авсан. Орхон аймгийн Жаргалант | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | сүлжээний зургийг шалгаж, хүлээн авсан байна. | сумын урд хойд хорооллын дулааны шугам татах байр зүйн дэвсгэр зургийн ажлын хүрээнд 400 га 1:1000-ний масштабтай байр зүйн зургийн ажлыг 2024 оны орон нутгийн төсөвт 59.9 сая төгрөгөөр “Од геодпроект” ХХК компани гүйцэтгэн 2024 оны 8 сард хүлээлгэн өгсөн. Орхон аймгийн Баян-Өндөр суманд 40 га буюу Цагаанчулуут багийн нутаг дэвсгэрт 20 га, Баянбулаг баг орчмын нутаг дэвсгэрт 20 га газарт 1:1000-ний масштабтай байр зүйн болон инженерийн шугам сүлжээний зураглалыг ITRF2020 солбицлын тогтолцоонд гүйцэтгэх ажилд “Би би кэй эйч” ХХК шалгарсан. 2024 оны орон нутгийн төсвөөс 42.5 сая төгрөгөөр байрзүйн дэвсгэр зургийн ажил хийгдэж байгаа бөгөөд 2024 оны 4-р улиралд хүлээн авна. | |
| **Стратеги төлөвлөгөөний зорилго 1.2.<br>Навигацын хиймэл дагуулаас мэдээ хүлээн авах суурин станцыг өргөжүүлэх замаар байрлалын сүлжээний нарийвчлалыг 2 см хүртэл сайжруулж, геодезийн хэмжил зураглалын үйл ажиллагаанд ашиглана.** | | | | | | | |
| **1.2.1** | **GNSS-ийн байнгын ажиллагаатай суурин станцын үйл ажиллагаа** | **Үйл ажиллагаа** | **1. Байнгын ажиллагаатай станц-43<br>2. Бодит агшны хяналтын хэмжилт - 4** | **2013-2017 онд Улсын төсвөөр 38, УБ хотын төсвөөр 5 станц суурилуулсан.<br>2019 онд GNSS-ийн байнгын ажиллагаатай 43 станцын нэгдсэн удирдлагын тогтолцоо бүрдүүлсэн.** | **43 Байнгын ажиллагаатай станцыг нэгдсэн сүлжээнд холбогдож, солбицол, өндрийн нэгдсэн тогтолцоонд алдаагүй зөв хэмжилт хийх боломж бүрдсэн байна.** | | |
| 1.2.1.1 | GNSS-ийн байнгын ажиллагаатай суурин станцын хэвийн үйл ажиллагааг хангах | Үйл ажиллагаа | Байнгын ажиллагаатай станцын тоо | 2013-2017 онд Улсын төсвөөр 38, нийслэлийн төсвөөр УБ хотод 5 станц суурилуулсан. | GNSS-ийн байнгын ажиллагаатай тасралтгүй хэвийн | Аймгийн ГХБХБГазрын ERDN GNSS-ийн байнгын ажиллагаатай станцын тасралтгүй хэвийн ажиллагааг хангаж бодит агшны | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | 2019 онд GNSS-ийн байнгын ажиллагаатай 43 станцын нэгдсэн удирдлагын тогтолцоо бүрдүүлсэн. | ажиллагааг хангаж ажилласан байна. | хэмжилт хийх нөхцөл боломжийг бүрдүүлэн ажиллаж байна. 2024 оны 09 дүгээр сарын 04- нд ERDN GNSS-ийн байнгын ажиллагаатай станцын программыг шинэчилж бодит агшны хэмжилтийг алдаагүй нарийвчлалтай хэмжих боломжийг сайжруулсан. | |
| 1.2.1.2 | Аймгийн төвийн GNSS-ийн байнгын ажиллагаатай суурин станцыг бодит агшны хэмжилтээр хяналт тавих | Үйл ажиллагаа | Бодит агшны хяналтын хэмжилт - 4 | 2020 онд GNSS-ийн байнгын ажиллагаатай станцын удирдлагын програм хангамжийг шинэчилж, хэрэглээнд нэвтрүүлсэн. | Аймгийн төвд суурилуулсан станцын бодит агшны нарийвчлалыг улиралд 1 удаагийн шалгалтын хэмжилт, сум суурин газрын станцуудад хагас жилд 1 удаагийн шалгалтын хэмжилт хийж, үр дүнг ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна. | Байнгын ажиллагаатай ERDN GNSS станцын бодит агшны 2-р улирлын хэмжилтийг 2024-06-14 өдөр хийж үр дүнг ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн. 3-р улирлын хэмжилтийг 2024-09-26-ний өдөр Trimple R12 багажаар геодезийн байнгын 5 цэг тэмдэгт дээр хийж үр дүн, тайланг 2024.09.27-ний өдрийн №710 албан тоотоор ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн. 4-р улирлын хэмжилтийг 2024 оны 10 дугаар сарын 29-ний өдөр Trimble R12 багажаар GPS-ийн сүлжээний ГЦТ6915, ГЦТ7297, ГЦТ1555, ГЦТ029, ГЦТ013 дугаартай цэгүүд дээр бодит агшны хэмжилт хийж үр дүн тайланг хүргүүлсэн. | 100 |
| **Стратеги төлөвлөгөөний зорилго 1.7.<br>Зайнаас тандан судлалын технологид суурилсан газар ашиглалт, газрын мониторингийн байнгын ажиллагаатай хяналтын системийг хөгжүүлж, нэвтрүүлнэ.** | | | | | | | |
| **1.7.1** | **Газар ашиглалт болон газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны мониторингийн сүлжээний мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх** | **Улсын төсөв** | **Мониторингийн 350 цэг** | **2021 онд мониторингийн сүлжээгээр байгуулсан 500 цэгт газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны ажил хийгдсэн.** | **Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны мониторингийн сүлжээний 1100 цэгээс мэдээлэл цуглуулж, дүн шинжилгээ хийж, бусад байгууллагууд ашиглах нөхцөл** | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | **боломжоор хангагдсан байна.** | | |
| 1.7.1.1 | Газрын төлөв байдал, чанарын хянан баталагаа хийлгэх шаардлагатай газрын байршил, хугацаа, хуваарийн талаарх судалгааг аймгийн хэмжээнд гаргаж ГЗБГЗЗЕГ-т хүргүүлэх | Үйл ажиллагаа | 1 судалгаа | - | **Эхний хагас жилд:** Сум болон холбогдох байгууллагаас газрын төлөв байдал, чанарын хянан баталгаа хийгдсэн газрын байршил, хугацааны талаарх судалгааг авч нэгтгэнэ. Тус судалгаанд дүн шинжилгээ хийж газрын төлөв байдал, чанарын хянан баталгаа хийлгах шаардлагатай газрын байршил, хугацаа, хуваарийн талаарх судалгааг аймгийн хэмжээнд гаргаж ГЗБГЗЗЕГ-т хүргүүлнэ. **Жилийн эцэст:** Тус ажлаар гарсан үр дүнг холбогдох хурлаар хэлэлцүүлэх, Газрын мониторингийн цахим системд ажлын үр дүнг оруулахад гүйцэтгэгч байгууллагыг мэргэжил, арга зүйгээр хангах, ажил гүйцэтгэх үе шатанд хяналт тавьсан ажлын тайланг ГЗБГЗЗЕГ-т хүргүүлэн ажилласан байна. | Орхон аймгийн Баян-Өндөр сумын хот тосгон, бусад суурин газрын нийт 4831.65 га талбайд “Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг” орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийх шаардлагатай тул 106,000,000 төгрөгийг 2025 оны орон нутгийн төсөвт тусгуулахаар Баян-өндөр сумын Засаг даргад 2024 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 769 тоот албан бичиг хүргүүлсэн.<br><br>2024 оны байдлаар аймгийн хэмжээнд Газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгаа хийх тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжээс газрын удирдлагын цахим илгээсэн хот тосгон, бусад суурин газар болон ХАА-н зориулалтаар ашиглаж байгаа нийт 571 иргэн, ААНБ-ын 52600 га газрын хянан баталгааны тайлан, дүгнэлтийг хуулийн хугацаанд нь баталгаажуулан, хянан баталгааны нэгдсэн тайлангийн хэрэгжилтийг гарган ГЗБГЗЗГазарт хүргүүлэн ажилласан.<br><br>Цахим системээр илгээж байгаа захиалгат хянан баталгааны тайлан, дүгнэлтийг баталгаажуулахад гарч буй нийтлэг алдаа, зөрчилд хяналт | **100** |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хийж тусгай зөвшөөрөл бүхий 4 ААНБайгууллагад тайлангийн зөрчил арилах талаар 2024 оны 09 дүгээр сарын 17-ны өдөр 679, 680, 681, 682 тоот албан бичгийг хүргүүлэн тайлан, дүгнэлтэд гаргаж буй зөрчлийг засварлаж, тайлангийн үр дүнг сайжруулсан. | |
| **1.7.2** | **Газар хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагааг зохион байгуулах, нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих** | **Орон нутгийн төсөв** | **Төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний тоо** | **Хүчтэй элэгдэл, эвдрэлд орсон тариалан болон атаршсан газарт нөхөн сэргээлт хийх төлөвлөгөө батлагдсан. Газрын мониторингийн системийг хэрэглээнд нэвтрүүлснээр газар хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагааг хянах боломж бүрдсэн.** | **Хүчтэй элэгдэл, эвдрэлд орсон тариалан болон атаршсан газарт нөхөн сэргээлт хийх төлөвлөгөөг хэрэгжүүлэх боломж бүрдсэн байна.** | | |
| 1.7.2.1 | Аймгийн хэмжээнд хохирол учирсан, доройтолд өртсөн газруудын байршлыг гаргаж, нөхөн сэргээх байршил, талбайн хэмжээг тодорхойлж, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах | Үйл ажиллагаа | 1 төлөвлөгөө | - | **Эхний хагас жилд:** Газрын нэгдмэл сангийн ангилал тус бүрээр хохирол учирсан, доройтолд өртсөн талбайн байршлыг тодорхойлж, нөхөн сэргээх үйл ажиллагааны төлөвлөгөөг аймгийн хэмжээнд боловсруулж, ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна. **Жилийн эцэст:** Нөхөн сэргээх үйл ажиллагааны төлөвлөгөөг сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгуулах, | 2024 оны Байгаль хамгаалах арга хэмжээний зардлаар Баян-өндөр сум Зэст багийн нутаг дэвсгэр БОЭТөвийн ар талын 13 га талбайд ойн нөхөн сэргээлт хийж, мод тарих хавар, намрын ажлын хүрээнд Хүрэн булгийн аманд 3 га талбайд, Эрдэнэтийн **Дулаан** цахилгаан станцын үнсэн сан орчим 1 га талбайд, Шанд багийн овоот толгойд 4,7 га талбайд, Эрдэнэт хаалганы урд хэсэгт 5 га, Хангал голын голдирол дагуу 17 га талбайд, нийт 30.7 га талбайд 1.3 сая ширхэг мод шинээр тарьж, ойжуулалт, ойн төгөл байгуулах ажил зохион байгуулж, нийт өссөн дүнгээр 123.46 га талбайд мод | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан байна. | тарьж, ойн төгөл, ойн зурвас байгууллаа.<br>Аймгийн хэмжээнд хохирол учирсан, доройтолд өртсөн нөхөн сэргээх үйл ажиллагааны хүрээнд 1.Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын биологийн нөхөн сэргээлт 1га Орхон аймгийн Баян-Өндөр сумын Эрдэнэ багийн нутаг дэвсгэрт Сархиа уулын зүүн урд энгэрт<br>2.Очир төв ХХК –ийн биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хүрээнд хийгдсэн биологийн нөхөн сэргээлт 1га Орхон аймгийн Баян-Өндөр сумын Эрдэнэ багийн нутаг дэвсгэрт Сархиа уулын зүүн урд энгэрт.<br>4.Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын Ил уурхайн III-р овоолго 1.9 га талбай<br>5.Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын Ил уурхайн Ү-р овоолго 2 га талбайд нийт 5 байршлын 5,9 га газарт биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах нөхөн сэргээлт хийгдсэн. | |
| 1.7.2.2 | Аймгийн хэмжээнд хийгдсэн хот, тосгон, бусад суурин газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгааны ажил болон төлөвлөгөөт хянан баталгааны ажлуудын тайлан, тоон мэдээллийг нэгтгэж, Газрын мониторингийн цахим системд оруулах | Үйл ажиллагаа | Цахим системд оруулсан тоон мэдээлэл | - | **Эхний хагас жилд:**<br>Газрын мониторингийн цахим системд ороогүй 2010-2023 оны хооронд хийгдсэн хот, тосгон, бусад суурин газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгааны тайлан, тоон мэдээллийг стандартын дагуу нэгтгэж мэдээллийн санг бий болгосон байна.<br>**Жилийн эцэст:** | Газрын мониторингийн цахим системд ороогүй 2010-2023 оны хооронд хийгдсэн хот, тосгон, бусад суурин газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгаа хийгдсэн иргэн, ААНБ-ын нэгж талбарын тайлан, тоон мэдээллийг стандартын дагуу нэгтэн Газрын мониторингийн цахим системд оруулахаар ажиллаж байна.<br>Аймгийн хэмжээнд хийгдсэн хот, тосгон, бусад суурин газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгааны ажлуудын тайлан, тоон мэдээллийг нэгтгэж | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Мэдээллийн санг Газрын мониторингийн цахим системд оруулсан байна. | тайлангийн хэрэгжилтийг гарган 2024 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн 749 тоот албан бичгээр ГЗБГЗЗГазарт хүргүүлэн ажилласан. | |
| 1.7.2.3 | Газар хамгаалах, нөхөн сэргээх зардлын зах зээлийн үнийн судалгаа хийх | Үйл ажиллагаа | Судалгаа-1 | - | **Эхний хагас жилд:** Газрын нөхөн сэргээлтийн ажлын үе шатыг нарийвчлан тодорхойлж, нөхөн сэргээлт хийгдэхэд шаардагдсан зардлын мэдээллийг цуглуулж, задаргааг тооцсон судалгааг ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна. | Газар хамгаалах, нөхөн сэргээлт хийгдэхэд шаардагдсан зардлын мэдээллийг цуглуулж, зах зээлийн үнийн судалгааг гарган ГЗБГЗЗЕГ-т албан тоот бичгээр хүргүүлсэн. | 100 |
| **1.7.3** | **Мониторингийн системд зайнаас тандан судлалын арга, технологийг нэвтрүүлэх** | **Урсгал төсөв** | **Суурь зургууд гарсан байна.** | **2020 оны 06 дугаар сарын 08-ны өдрөөс Газрын мониторингийн системийг хэрэглээнд нэвтрүүлсэн.** | **Мониторингийн системд зайнаас тандан судлалын арга, технологийг ашиглах нэмэлт хөгжүүлэлт хийсэн байна.** | | |
| 1.7.3.1 | Газрын мониторингийн үйл ажиллагаанд зайнаас тандан судлалын арга, технологийг ашиглан, газрын бүрхэвчийн өөрчлөлт, доройтол, элэгдэл, эвдрэл, бэлчээрийн газрын даац, чадавхыг тодорхойлох | Үйл ажиллагаа | Ирүүлсэн тайлангийн тоо | БХБС-ын 2022 оны 126 дугаар тушаалаар “Зайнаас тандан судлалын аргаар бэлчээрийн газрын мониторинг хийх аргачилсан заавар” батлагдсан. | **Жилийн эцэст:** Газрын даамал, мэргэжилтнүүдийг мэргэжил арга зүйгээр хангаж, хиймэл дагуулын 6-9 дүгээр сарын мэдээнд үндэслэн сум тус бүрээр ургамлын бүрхэвчийн зураглалыг хийж, бэлчээрийн газрын биомасс, даацыг тооцон аймгийн хэмжээнд элэгдэл, эвдрэл, доройтолд өртсөн газрыг тодорхойлж, үр дүнг ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна. | Аймгийн 2024 оны бэлчээрийн газрын төлөв байдлын өөрчлөлтийг зайнаас тандан судлалын арга, технологийг ашиглан хиймэл дагуулын 6-9 дүгээр сарын мэдээнд үндэслэн ургамлын бүрхэвчийн зураглалыг хийж, бэлчээрийн газрын биомасс, даацыг тооцон аймгийн хэмжээнд элэгдэл, эвдрэл, доройтолд өртсөн газрыг тодорхойлж, тайланг ГЗБГЗЗЕГ-т 2024 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 768 тоот албан бичгээр хүргүүлсэн. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Стратеги төлөвлөгөөний зорилго 1.8.<br>Газар, байгаль, эдийн засаг, нийгмийн нөөц, чадавхад тулгуурлан газар ашиглалт, хамгаалалтын үр ашгийг дээшлүүлэх, газрыг иргэд болон эдийн засгийн хувьд үндэслэл сайтай, үр ашигтай, экосистемийн тэнцвэрт байдлыг хангасан газар зохион байгуулалтыг хөгжүүлж, газрын нөөцүүдийг оновчтой ашиглаж хэвшинэ.** | | | | | | | |
| **1.8.1** | **Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах** | **Үйл ажиллагаа** | **Улсын хэмжээний тайлан** | **2018 онд Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж, батлуулсан.** | **Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж, явцыг жил бүр Засгийн газарт танилцуулсан байна.** | | |
| 1.8.1.1 | Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний 2023 оны хэрэгжилтийг гаргаж ГЗБГЗЗЕГ-т хүргүүлэх | Үйл ажиллагаа | Хэрэгжилтийн тайлан-1 | Засгийн газрын 2018 оны 384-р тогтоолоор Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө батлагдсан. | **Эхний хагас жилд:**<br>Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний 2023 оны хэрэгжилтийг 1-р улиралд багтаан гаргаж, ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна. | Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний 2023 оны хэрэгжилтийн биелэлтийг 18 арга хэмжээний хүрээнд гаргаж аймгийн 2023 оны газрын нэгдмэл сангийн тайлантай хамт 2024 оны 01 дүгээр сард ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн. | 100 |
| **1.8.3** | **Аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд хяналт тавих** | **Үйл ажиллагаа** | **8 аймгийн болон нийслэлийн Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө** | **12 аймгийн Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулсан.** | **Шинэчлэн боловсруулсан газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийж, үр дүнг холбогдох аймгуудад хүргүүлсэн байна.** | | |
| 1.8.3.1 | Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, тайлагнах | Үйл ажиллагаа | Хэрэгжсэн арга хэмжээний тоо | 18 аймгийн ГЗБЕТ (Говьсүмбэр, Увс, Завхан, Хөвсгөл, Өмнөговь, Дундговь, Төв, Дархан-Уул, Дорноговь, Баян-Өлгий, Булган, Баянхонгор, Орхон, Архангай, Хэнтий, | **Эхний хагас жилд:**<br>Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний дагуу хийгдэх ажлуудыг зохион байгуулсан байна. | Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг /2022-2037он/ хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах ажлыг 28 арга хэмжээний хүрээнд Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим системд төсөл үүсгэн | **100** |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Сүхбаатар, Дорнод, Сэлэнгэ) боловсруулсан. | **Жилийн эцэст:** Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний дагуу хийгдэх ажлуудыг зохион байгуулсан байна. Хэрэгжилтийг 12 дугаар сарын 20-ны дотор тайлагнасан байна. | мөрдлөг болгон хэрэгжүүлэн ажиллаж байна.<br><br>Үүний хүрээнд аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан Баян-Өндөр, Жаргалант сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусган сумдын ИТХ–аар батлуулсан.<br>Мөн Жаргалант сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг тусгай зөвшөөрөлтэй “Газар орчин” ХХК гүйцэтгэн Жаргалант сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны 09 сарын 21-ны өдрийн ээлжит бус IV хурлын 02 тоот тогтоолоор батлан, ажлыг хүлээж авсан. | |
| 1.8.3.2 | Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөтэй холбоотой мэдээ, судалгааг холбогдох байгууллагад хүргүүлэх | Үйл ажиллаг аа | Судалгаа, мэдээллийн тоо | 18 аймгийн ГЗБЕТ (Говьсүмбэр, Увс, Завхан, Хөвсгөл, Өмнөговь, Дундговь, Төв, Дархан-Уул, Дорноговь, Баян-Өлгий, Булган, Баянхонгор, Орхон, Архангай, Хэнтий, Сүхбаатар, Дорнод, Сэлэнгэ) боловсруулсан.<br>175 сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулагдсан. | Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөтэй холбоотой мэдээлэл, судалгааг ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна. | Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөтэй холбоотой 2 судалгааг гаргаж хугацаанд хүргүүлсэн. | 100 |
| **1.8.4** | **Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах** | **Орон нутгийн төсөв** | **16 сум** | **98 сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулж, баталгаажуулсан.** | **Жил бүр 18 сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулах ажлыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллана.** | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.8.4.1 | Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, тайлагнах. | Үйл ажиллагаа | Хэрэгжсэн арга хэмжээний тоо | Улсын хэмжээнд 175 сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө батлагдсан. | **Эхний хагас жилд:** Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний дагуу хэрэгжих ажлуудыг зохион байгуулж ажилласан байна. **Жилийн эцэст:** Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний дагуу хэрэгжих ажлуудыг зохион байгуулж, цахим системд байршуулсан байна. Хэрэгжилтийг 2024 оны 12 дугаар сард багтаан тайлагнасан байна. | Жаргалант сумын Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах ажлыг “Газар орчин” ХХК нь Жаргалант сумын Засаг даргын тамгын газартай дугаар А/01 тоот гэрээ байгуулан Жаргалант сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн 02 тогтоолоор батлуулсан. Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим системд 2024-06-061-8350 дугаартай төсөл үүсгэн байршуулсан. Төлөвлөгөөнд 33 арга хэмжээний хүрээнд 314 нэгж талбарыг тусгасан. | 100 |
| 1.8.4.2 | Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг шинээр боловсруулах, тодотгох талаар аймаг, орон нутгийн удирдлагуудыг мэдээ, танилцуулгаар хангаж төлөвлөгөөний зардлыг төсөвт суулгах ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Санхүүжилтын хэмжээ | - | **Эхний хагас жилд:** Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг шинээр боловсруулах болон тодотгоход шаардагдах зардлыг орон нутгийн төсөвт суулгуулах талаарх санал болон танилцуулгыг холбогдох албан тушаалтанд танилцуулах ажлыг зохион байгуулсан байна. **Жилийн эцэст:** Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг шинээр боловсруулах болон тодотгоход шаардагдах зардлыг | Нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах зайлшгүй хэрэгцээ шаардлагыг үндэслэн сумын удирдлагууд, холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, Жаргалант сумын 2024 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэх ажлын жагсаалтад 18,8 сая төгрөг тусгуулан батлуулсан. Төлөвлөгөөнд тусгах шаардлагатай үзүүлэлтүүдийг нэгтгэж сумын удирдлагуудыг тухай бүрд нь мэдээ мэдээллээр хангаж ажиллаж байна. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 2025 оны төсөвт тусгуулах ажлыг зохион байгуулж, батлуулсан байна. | Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг тулгуурлан 2025 оны орон нутгийн төсөвт Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардалд 18 сая төгрөг тусгасан.<br>Орхон аймгийн хэмжээнд шинээр сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг шинээр боловсруулах болон тодотгох шаардлагатай сум байхгүй болно. | |
| 1.8.4.3 | Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг шинээр боловсруулах болон тодотгон боловсруулах ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Дүгнэлтийн тоо | Улсын хэмжээнд 175 сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө батлагдсан. | **Эхний хагас жилд:**<br>Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах ажлын даалгаврыг боловсруулж, хянуулан батлуулсан байна.<br>Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах ажлыг зохион байгуулж, төлөвлөгөө боловсруулах явцад хяналт тавьж, үе шат бүр дээр дүгнэлт гаргаж ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна.<br>**Жилийн эцэст:**<br>Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах явцад хяналт тавьж, ГЗБГЗЗЕГ-аас гаргасан мэргэжлийн дүгнэлтийг үндэслэн засвар, өөрчлөлтийг гүйцэтгэгчээр хийлгэж, сумын ИТХ-аар хэлэлцүүлэх ажлыг | Жаргалант сумын Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах ажлыг Газар орчин ХХК нь Жаргалант сумын Засаг даргын тамгын газартай дугаар А/01 тоот гэрээ байгуулан хээрийн хэмжилт судалгааны ажлыг боловсруулан нягталж 2024 оны 1 дүгээр сард багийн Иргэдийн нийтийн хурлаар нийт 55-70 иргэд цуглан сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөнд санал авах ажлыг зохион байгуулсан.<br>2024 оны 4 дүгээр сард Хээрийн хэмжилт судалгаа болон Багийн иргэдийн нийтийн хурлаас гарсан бүх төлөвлөлтийн саналыг боловсруулан эцсийн байдлаар Жаргалант сумын Засаг дарга, болон албан хаагч, мэргэжилтнүүд иргэдийн төлөөлөл, ажлын хэсгийг хуралдуулан танилцуулга хийсэн.Тус уулзалтаар сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөнд төлөвлөлтийн санал нэмэгдсэнийг боловсруулан цэгцэлж 2024 оны 5 дугаар сард | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | зохион байгуулж ажилласан байна. | Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөний төслийг мэргэжлийн байгууллагаар хянуулахаар Газар зохион байгуулалт геодези зураг зүйн ерөнхий газрын цахим системд байршуулсан.<br>Жаргалант сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд дүгнэлт гаргаж 2024 оны 538 тоотоор гүйцэтгэгч байгууллага болон ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн.<br>Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлж 2024 оны 09 сарын 12-ны өдрийн 02 тогтоолоор батлуулсан. | |
| **Стратеги төлөвлөгөөний зорилго 1.9.<br>Мэдлэгт суурилсан, иргэд, олон нийтийн оролцоотой газар зохион байгуулалтын нэгдсэн төлөвлөлтийн системийг бий болгоно.** | | | | | | | |
| **1.9.1** | **Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг нийгэм, эдийн засаг, хүн амын өсөлт, байгалийн нөхцөл, нөөцийн чадавхид нийцүүлэн оновчтой зохион байгуулах, хуваарилах** | **Үйл ажиллаг аа** | **Аймаг бүрээр боловсруулса н санал** | **21 аймаг, 330 сумын хилийн цэсийг тодотгосон.** | **Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хилийн цэсийг боловсронгуй болгох саналыг боловсруулж, ЗГХЭГ-т хүргүүлсэн байна.** | | |
| 1.9.1.1 | Барилга, хот байгуулалтын сайдын 2023 оны 24 дүгээр тушаалаар байгуулагдсан "Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хилийн цэсийн маргааныг шийдвэрлэх талаар санал, дүгнэлтийг гаргах үүрэг бүхий Ажлын хэсэг"-ээс гаргасан дүгнэлтийн дагуу орон нутгийн удирдлагууд, иргэд, олон нийтэд хилийн цэсийн | Үйл ажиллаг аа | Тайлан хүргүүлсэн байдал | Бүх сумдын хилийн цэсийг тодотгосон. | Орон нутгийн удирдлагууд, иргэд, олон нийтэд хилийн цэсийн талаарх үнэн зөв мэдээллийг өгөх ажлыг зохион байгуулж, тайланг ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна | Орхон аймгийн Баян-Өндөр, Жаргалант сумын хилийн цэсийн судалгааг ГЗБГЗЗЕГ-аас ирүүлсэн загварын дагуу гаргаж мэдээллийн сан үүсгэн 2024.04.10-ны өдрийн 186 тоот албан бичгээр судалгааг тоон мэдээллийн хамт ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн.<br>2024 оны 02 дугаар сард аймгийн Засаг даргын Жаргалант сумын иргэдтэй уулзалтын үеэр Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн сумтай | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | талаарх үнэн зөв мэдээллийг өгөх ажлыг зохион байгуулж, тайлан, мэдээг ГЗБГЗЗЕГ-т хүргүүлэх | | | | | үүсдэг хилийн цэсийн маргаан, хадлангийн талбайн асуудлаар иргэдээс санал хүсэлт гаргасны дагуу ГХБХБГазрын зүгээс мэдээлэл өгч, зөрүүтэй ойлголтуудад тайлбар хийсэн. Орхон аймгийн Жаргалант сумын хилийн цэсийг УИХ-ын 1994 оны 32 дугаар тогтоолоор баталсан цагаас хойш 3 удаа хилийн цэсийн маргааныг тодруулах ажил хийгдэж 1:25000,1:75000, 1:100000 масштабтай зураг үйлдэж зурагласан байдаг. 2024 онд Жаргалант сумын орон нутгийн төсвийн хөрөнгөөр газарзүйн нэрийн тодруулалтын ажлыг хийж гүйцэтгэж суурин судалгааны ажил 2024 оны 2-4 дүгээр сард, хээрийн судалгааны ажил 4-7 дугаар сард хийгдсэн. Жаргалант сумын хувьд Чулуун хөшөө, Бүдүүн хуст гэх 2 газарт маргаан их гардаг. Хээрийн болон суурин судалгааны боловсруулалтын үр дүнд хилийн цэст маргаан байхгүй болохыг тодруулсан. Нутгийн иргэдийн Антентай толгой гэж нэрлэдэг уулын албан ёсны газарзүйн нэршил нь Бүдүүн хуст уул, Чулуун хөшөөг зөөж хөдөлгөсөн асуудал байхгүйг бүх судалгаа, хэмжилт, зураглал нотолсон. | |
| **Стратеги төлөвлөгөөний зорилго 1.13.**<br>**Төрийн үйлчилгээний ил тод байдлыг хангаж, цахим үйлчилгээг хөгжүүлэх замаар салбарын хэмжээнд цахим шилжилт хийх үйл ажиллагааг дэмжих** | | | | | | | |
| **1.13.2** | **Салбарын үйл ажиллагаанд цахим гарын үсэг болон тоон гарын үсэг нэвтрүүлэх** | **Үйл ажиллагаа** | **85 тоон гарын үсэг** | **Салбарын хэмжээнд нийт 649 тоон гарын үсгийг шинэчлэн олгосон.** | **Газрын харилцааны салбарын нийт албан хаагчид тоон гарын үсэг ашигладаг болсон байна.** | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.13.2.1 | Тоон гарын үсгийн олголт хийх, өдөр тутмын үйл ажиллагаанд ашиглах боломжийг нэвтрүүлэх | Үйл ажиллагаа | - Тоон гарын үсэг эзэмшигчийн тоо<br>- Тоон гарын үсгийг ашиглаж буй үйл ажиллагааны тоо | Салбарын хэмжээнд нийт 649 тоон гарын үсгийг шинэчлэн олгосон. | - Тоон гарын үсгийн олголтыг шинэчлэн хийсэн байна.<br>- Байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаанд тоон гарын үсгийг ашигладаг болсон байна. | Байгууллагын 12 албан хаагч гар утасны GSign тоон гарын үсэг, байгууллагын дарга, ерөнхий нягтлан бодогч нар Monpass XXK-ний тоон гарын үсгийг өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэглэж байна. | 100 |
| **Стратеги төлөвлөгөөний зорилго 1.14.<br>Төрийн архивын стандарт орчныг сайжруулах** | | | | | | | |
| **1.14.1** | **Төрийн архивыг цахимжуулах, цахим мэдээллийн сан бүрдүүлэх, цахим үйлчилгээг нэвтрүүлэх** | **Үйл ажиллагаа** | **1764 хадгаламжийн нэгж** | **2022 онд Төрийн архивын 14879 хадгаламжийн нэгжийн баримтыг архивын цахим системд холбосон.** | **1764 хадгаламжийн нэгжийн баримтыг архивын цахим системд холбоно.** | | |
| 1.14.1.1 | Архивын баримтыг цахимжуулах, цахим мэдээллийн сан үүсгэх | Үйл ажиллагаа | Цахимжуулсан хадгаламжийн нэгжийн тоо | 2023 оны байдлаар 90 хадгаламжийн нэгжийн 100 хуудас баримт цахимжсан. | **Эхний хагас жилд:**<br>50 хадгаламжийн нэгжийн баримтыг цахимжуулан Архивын цахим системд холбон, байнгын үйл ажиллагааг хангахад ГЗБГЗЗЕГ-ын Салбарын архивын хэлтэстэй хамтран ажиллаж холбогдох зааварчилгаа авсан байна.<br>**Жилийн эцэст:**<br>50 хадгаламжийн нэгжийн баримтыг цахимжуулан Архивын цахим системд холбон, байнгын үйл ажиллагааг хангахад ГЗБГЗЗЕГ-ын Салбарын архивын хэлтэстэй хамтран ажиллаж холбогдох | Байгууллагын БНШК-ын 2023 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн хуралдаанаар батлагдсан ХХНЖ-ын дагуу 106 хадгаламжийн нэгжийн баримтын бүрдлийг шалган архивд 2024 онд хүлээн аван, архивын баримт үдэх стандартын дагуу үдэж нүүрэлсэн. Үүнээс archive.gazar.gov.mn цахим мэдээллийн санд 2024 онд нийт байдлаар 11254 хуудас бүхий 213 хадгаламжийн нэгжийг 300*300 dpi нягтралаар цахимжуулан холбоод байна.<br>Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газраас зохион байгуулсан архив, албан хэрэг хөтлөлтийн ажилтнуудын чадавхыг сайжруулах, үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, архивын цахим системийг танилцуулах, мэргэжил арга зүйн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | зааварчилгаа авсан байна. | зөвлөгөө өгөх зорилго бүхий сургалтад 2024.10.24-2024.10.25-ны өдрийн хооронд архивын ажилтан Улаанбаатар хотод танхимаар хамрагдсан. | |
| **Стратеги төлөвлөгөөний зорилго 1.15.<br>Төрийн болон албаны нууцыг хадгалж хамгаалах** | | | | | | | |
| **1.15.1** | **Төрийн болон албаны нууцыг хадгалж хамгаалах, хяналт тавих** | **Үйл ажиллагаа** | **Зохион байгуулсан ажлын тоо** | **-** | **Төрийн болон албаны нууцыг хадгалж, хамгаалах талаарх ажлуудыг зохион байгуулсан байна.** | | |
| 1.15.1.1 | Төрийн болон албаны нууцыг хадгалж, хамгаалах, хяналт тавих, Нууц албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг зохион байгуулж, хэрэгжүүлэх | Үйл ажиллагаа | 1 мэдээ,<br>1 тооллого | 2023 онд Төрийн болон албаны нууцын хадгалалт, хамгаалалтын чиглэлээр явуулсан үйл ажиллагааны мэдээг ГЗБГЗЗГ-т хүргүүлсэн.<br>2023 онд Төрийн болон албаны нууцын тооллого хийж, дүн мэдээг хугацаанд нь явуулсан. | Төрийн болон албаны нууцын хадгалалт, хамгаалалтын чиглэлээр 2024 онд хэрэгжүүлсэн ажлын мэдээг 2024 оны 12 дугаар сарын 10-ны дотор ТЕГ-ын орон нутаг дахь Тагнуулын газар, ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна.<br><br>Нууцын албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг зохион байгуулж, нууц баримттай танилцах иргэний итгэмжлэлийг шинэчлэх, нууцын баталгаа авах, нотлох лавлагаа гаргаж өгөх, гадаад улсад зорчих эрх бүхий албан тушаалтан, мэргэжилтний урьдчилсан мэдүүлгийг авах, шилжилт хөдөлгөөний мэдээллийг тус тус бүртгэлжүүлж, мэдээ тайланг ТЕГ-ын | 2024 онд албаны нууцын зэрэглэлтэй 2 албан бичиг ирж, холбогдох журмын дагуу бүртгэл хөтлөн ажиллаж байна. Газрын даргын 2023 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн А/07 дугаар тушаалаар төрийн болон албаны нууцтай танилцах эрх бүхий албан тушаалтны жагсаалтыг шинэчлэн батлуулсан. Улсын тусгай хэрэгцээнд авсан Зэвсэгт хүчний 186 дугаар ангийн 5 газрын байршилд тулган хийн 2023 оны 03 дугаар сард аймгийн Засаг даргын захирамжаар баталгаажуулж, гэрээ, гэрчилгээжүүлэх ажил хийгдэж байна.<br>2024 оны 11 дүгээр сарын 12 өдөр Тагнуулын ерөнхий газрын Орхон аймаг дахь тагнуулын газартай хамтран байгууллагын албан хаагчдад Төрийн болон албаны нууцын талаарх хууль, тогтоомжийг сургалтыг танхимаар зохион байгуулсан.<br>2024 онд Төрийн болон албаны нууцаар 6 бичиг ирж холбогдох | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | орон нутаг дахь Тагнуулын газар, ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна.<br>Аймгийн ГХБХБГ-ын төрийн болон албаны нууцын хадгалалт хамгаалалтын үзлэг тооллого хийсэн байна.<br>Тооллогын мэдээг ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна. | байгууллагад хуулийн дагуу хүргүүлсэн.<br>Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар нь "Төрийн болон албаны нууцын тухай" хууль, "Төрийн болон албаны нууцыг хамгаалах нийтлэг журам", Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын тушаалаар батлагдсан "Төрийн болон албаны нууц хамгаалах тухай" байгууллагын дотоод журамд заасны дагуу төрийн нууцад хамаарах 15 ширхэг зураг, зөөврийн хард дискт хадгалагдах 22 ширхэг файл, мэдээ материалыг зориулалтын өрөө, сейфэнд, мөн албаны нууцад хамаарах архивын сан хөмрөгт хадгалагдаж буй газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагч иргэн, аж ахуйн нэгж байгууллагын 26000 нэгж талбарын хувийн хэргийг зориулалтын өрөөнд хадгалж байна. | |
| **Стратеги төлөвлөгөөний зорилго 1.20.**<br>**Хот байгуулалтын кадастрын мэдээллийн сангийн суурь өгөгдлийг бүрдүүлэх, мэдээллийн нэгдсэн системийг бүрэн ашиглалтанд оруулж, хэрэглээнд нэвтрүүлнэ.** | | | | | | | |
| **1.20.1** | **Инженерийн дэд бүтэцтэй холбоотой мэдээллийг Хот байгуулалтын кадастрын мэдээллийн санд бүртгэх** | **Үйл ажиллагаа** | **Инженерийн дэд бүтцийн мэдээлэл** | **-** | **Төлөвлөлтийн инженерийн дэд бүтэц, бэлтгэл ажлын мэдээллийг хот байгуулалтын кадастрын цахим системд бүртгэсэн байна.** | | |
| 1.20.1.1 | Инженерийн дэд бүтэц, инженерийн бэлтгэл арга хэмжээний орон зайн тоон зургийг холбогдох хангагч, | Үйл ажиллагаа | Төлөвлөлтийн 7 давхаргын мэдээлэл | - | Аймгийн хэмжээнд Хот байгуулалтын кадастрын системд төлөвлөлтийн 7 | 2024 оны жилийн эцсийн байдлаар Хот байгуулалтын кадастрын мэдээллийн санд Инженерийн дэд | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | ашиглалт хариуцсан байгууллагатай хамтран баяжилт хийх, мэдээллийг Хот байгуулалтын кадастрын мэдээллийн санд бүртгэх ажлыг зохион байгуулах | | | | давхаргын мэдээллийг бүртгэсэн байна. | бүтцийн чиглэлээр дараах мэдээллийг бүртгэж баяжуулалт хийгдсэн. Үүнд:<br>1. Цэвэр усны 930м шугам<br>2. Дулааны 1392м шугам<br>3. Ариутгах татуургын 583м шугам<br>4. Хэрэглээний халуун усны 642м шугам | |
| **1.20.2** | **Хот байгуулалтын кадастрын мэдээллийн санг танилцуулах, сурталчилах** | **Үйл ажиллагаа** | **2 арга хэмжээг авч хэрэгжүүлэх** | **-** | **Хот байгуулалтын кадастрын мэдээллийн нэгдсэн системийг сурталчилсан байна.** | | |
| 1.20.2.1 | Хот байгуулалтын кадастрын цахим системийг олон нийтэд сурталчилах | Үйл ажиллагаа | 4 арга хэмжээ | - | **Эхний хагас жилд:**.<br>Хот байгуулалтын кадастрын цахим системийг олон нийтэд сурталчлах чиглэлээр 2 арга хэмжээг зохион байгуулж хэрэгжүүлсэн байна.<br>**Жилийн эцэст:**<br>Хот байгуулалтын кадастрын цахим системийг олон нийтэд сурталчлах чиглэлээр 2 арга хэмжээг зохион байгуулж, хэрэгжүүлсэн байна. | 2024 онд хот байгуулалтын кадастрын мэдээллийн санг сурталчлах ажлын хүрээнд 5 төрлийн арга хэмжээ зохион байгуулан 2500 гаруй иргэн, аж ахуйн нэгж байгууллагын төлөөлөлд танилцуулга мэдээлэл өгсөн. Үүнд:<br>1. 1280 иргэн, аж ахуйн нэгж байгууллагад утсаар болон биечлэн мэдээлэл хүргэж заавар зөвлөгөөг танилцуулан ажилласан.<br>2. Байгууллагын албан ёсны мэдээллийн 5200 гаруй дагагчтай олон нийтийн ***www.facebook.com/erdenetgazar*** буюу Орхон аймгийн газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын цахим хуудсаар болон харилцагч байгууллагуудаар дамжуулан салбарын үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг орон нутгийн хэмжээнд сурталчлан ажиллаж байна.<br>3. “Барилгын салбарын удирдах ажилтны зөвлөгөөн 2024” арга хэмжээ “Аюулгүй барилга, аюулгүй | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | орчин, аюулгүй ажиллагаа“ уриа нь дор 2024.04.05-ны өдөр төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжүүд, инженер, техникийн нийслэл, 21 аймгаас ирсэн төр, хувийн хэвшлийн 400 гаруй салбарын төлөөлөл оролцсон. 4.“Орхон аймгийн бүтээн байгуулалт-2024” нээлттэй өдөрлөг 04 сарын 24-нд Баасан гарагт А.Амарын талбайд зохион байгуулагдсан. Өдөрлөгөөр Орхон аймагт улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй ажлууд, хот байгуулалтын цахим системийн хэрэглээ, барилгын лабораторийн үйл ажиллагаа, газрын харилцааны чиглэлийн зөвлөгөө, мэдээллийг нийт 400 гаруй иргэдэд хүргэн ажиллалаа. Мөн барилга, авто замын материал үйлдвэрлэгч ААН-үүд оролцож, шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг танилцуулсан. 5.“Эрдэнэ шинэ илгээлт 50” төслийн хүрээнд “Төлөвлөлттэй хот” танилцуулгыг Амарын талбайд 2024.09.17-оос хойш 7 хоногийн хугацаанд Эрдэнэт хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтийн талаар иргэдэд танилцуулах ажлыг зохион байгуулсан. | |
| **Стратеги төлөвлөгөөний зорилго 1.21.**<br>**Хяналт шалгалтын үйл ажиллагааны үр дүн, бүтээмжийг дээшлүүлнэ.** | | | | | | | |
| **1.21.1** | **Аймгийн хэмжээнд газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагчдад хяналт шалгалт хийх** | **Үйл ажиллагаа** | **Хэрэгжилтийн хувь** | **-** | **Газар зохион байгуулалтын төлөвлөгөө болон газрын төлөв байдал,** | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | **чанарын хянан магадлагааны хэрэгжилтийг 80%-д хүргэсэн байна.** | | |
| 1.21.1.1 | Аймгийн хэмжээнд газар, геодези, зураг зүйн чиглэлээр их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн 24 объектод төлөвлөгөөт хяналт шалгалт хийх | Үйл ажиллагаа | Шалгалт хийсэн объектын тоо, гүйцэтгэлийн хувь, хууль сахин мөрдөлтийн түвшин, илрүүлсэн зөрчил, арилгуулалтын хувь, улсын байцаагчийн гаргасан шийдвэрийн биелэлт, эрсдэлийн түвшин буурсан объектын тоо, хувь | - Их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн 576 объектод төлөвлөгөөт шалгалт хийхээр “Хяналт шалгалтын төлөвлөгөөг” Засгийн газрын 2023 оны 79 дүгээр тогтоолоор батлуулсан.<br>- Барилга, хот байгуулалтын Сайдын 2023 оны 74 дүгээр тушаалаар батлуулсан. | Шалгалтаар их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн нийт объектын эрсдэлийн түвшинг бууруулсан байна. Хяналтын хуудсаар илэрсэн зөрчлийг арилгуулсан байна. Улсын байцаагчийн гаргасан шийдвэрийн биелэлтийг бүрэн хангуулсан байна. | Төлөвлөгөөт хяналт шалгалтад Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн ерөнхий газрын даргын 2024 оны А/53 дугаар тушаалаар батлагдсан 10 объект төлөвлөгөөт хяналт шалгалт хийхээр төлөвлөснөөс 1 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулаагүй нийт 9 объектын 2 иргэн 7-н аж ахуйн нэгжийг хяналт шалгалтад бүрэн хамруулж холбогдох хяналтын хуудсаар үнэлгээ өгч ажиллаа. Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах тухай албан шаардлагыг 2 иргэн 7 аж ахуйн нэгжид 102 заалт бүхий хугацаатай албан шаардлага өгч хэрэгжилтийг хангуулан ажиллаа. Хяналт шалгалтын ажлыг иж бүрэн ХББОСЯ-ны шилэн хяналтын системд улирал бүрээр оруулж байна. жилийн эцсээр төлөвлөгөөт шалгалт 15, урьдчилан сэргийлэх хяналт 41, эрсдэлийн үнэлгээ хийсэн объект 100 барилга байгууламж үнэлгээ хийж шилэн хяналтад оруулсан байна. | 100% |
| 1.21.1.2 | Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийн “Газрын кадастрын цахим систем”-д нэгж талбарын цахим хувийн хэргийн бүрдүүлэлтэд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх. | Үйл ажиллагаа | Хяналт шалгалтад хамрагдсан объектын тоо, гүйцэтгэлийн хувь,<br><br>хууль сахин мөрдөлтийн түвшин, | Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийн “Газрын кадастрын цахим систем”-д нэгж талбарын цахим хувийн хэргийн бүрдүүлэлтэд хяналт хийх, дүгнэлт гаргах, авах арга хэмжээний саналыг боловсруулах үүрэг бүхий | Батлагдсан удирдамжийн хүрээнд хяналт шалгалтыг хийж илэрсэн зөрчлийг арилгуулсан байна. Шалгалтын дүнг хурлаар хэлэлцүүлэн, илэрсэн зөрчлийг бүрэн арилгуулах арга хэмжээг | Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын даргын 2024 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн 35-00/08 дугаар “Урьдчилан сэргийлэх шалгалт хийх тухай” удирдамжийн дагуу Орхон аймгийн Баян-Өндөр, Жаргалант сумдын газрын нэгдмэл сангийн удирдлагын системд бүртгэлтэй 138 нэгж талбарыг | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | илрүүлсэн зөрчил, арилгуулалтын хувь, улсын байцаагчийн гаргасан шийдвэрийн биелэлт | ажлын хэсэг байгуулагдаж, удирдамжийн дагуу цахим системд үүсгэсэн хувийн хэргийн 1.2 хувь буюу 13,501 нэгж талбарын хувийн бүрдүүлэлтэд хяналт хийсэн. | зохион байгуулсан байна.<br>Улсын байцаагчийн гаргасан шийдвэрийн биелэлтийг бүрэн хангуулсан байна. | түүврийн аргаар сонгон хяналт шалгалтыг хийж илэрсэн зөрчлийг арилгуулан ажилласан. | |
| 1.21.1.3 | Тусгай зөвшөөрөлтэй болон мэргэжлийн байгууллагын эрхтэй хуулийн этгээдийн үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх | Үйл ажиллагаа | Шалгалт хийсэн объектын тоо, илрүүлсэн зөрчил, арилгуулалтын хувь, улсын байцаагчийн гаргасан шийдвэрийн биелэлт, эрсдэлийн түвшин буурсан объектын тоо | - | Батлагдсан удирдамжийн хүрээнд хяналт шалгалтыг хийж илэрсэн зөрчлийг арилгуулсан байна.<br>Дүнг холбогдох хурлаар хэлэлцүүлэн, илэрсэн зөрчлийг бүрэн арилгуулах арга хэмжээг зохион байгуулсан байна.<br>Улсын байцаагчийн гаргасан шийдвэрийн биелэлтийг бүрэн хангуулсан байна. | ХББОСЯ-ны 02-00/08 удирдамжаар шинээр баригдаж байгаа орон сууц, олон нийтийн 17 барилгад урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийж, 17 зөвлөмж өгч 6 барилгын захиалагч иргэнд БАЭЗ аваагүй гэдэг заалтаар Зөрчлийн тухай хуулиар торгуулийн арга хэмжээ авлаа.<br>Салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан 2024 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн 35-00/12 дугаартай урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх удирдамжийн дагуу геодези, зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй мэргэжлийн “ГМОМОН”ХХК, “Эрд кадастр” ХХК, “Их нэмүүн констракшн” ХХК, “Од геопроект” ХХК, “Би би кэй эйч” ХХК нийт 5 байгууллагыг хяналт шалгалтад бүрэн хамруулж холбогдох хяналтын хуудсаар үнэлгээ өгч ажиллаа.<br>Хууль сахин мөрдөлтийн хувь дунджаар 71,6%, эрсдэл үүсэх магадлал дунджаар 28.4% үнэлэгдсэн.<br>Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах тухай 5 аж ахуйн нэгжид 18 заалт бүхий хугацаатай албан шаардлага өгч | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 13 заалт бүхий зөрчлийг арилгуулан ажилласан. | |
| 1.21.1.4 | Соёл, урлагийн байгууллагын газар эзэмшил, ашиглалтын байдалд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх | Үйл ажиллагаа | Шалгалт хийсэн объектын тоо, илрүүлсэн зөрчил, арилгуулалтын хувь, улсын байцаагчийн гаргасан шийдвэрийн биелэлт, эрсдэлийн түвшин буурсан объектын тоо | - | Батлагдсан удирдамжийн хүрээнд хяналт шалгалтыг хийж илэрсэн зөрчлийг арилгуулсан байна.<br>Дүнг холбогдох хурлаар хэлэлцүүлж, илэрсэн зөрчлийг бүрэн арилгуулах арга хэмжээг зохион байгуулсан байна.<br>Улсын байцаагчийн гаргасан шийдвэрийн биелэлтийг бүрэн хангуулсан байна. | Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн салбарын Улсын ерөнхий байцаагч болон Соёлын салбарын Улсын ерөнхий байцаагч нарын 2024 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн 35-00/06, 05-00-00-001/07 дугаар бүхий “Урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай” хамтарсан удирдамжийн дагуу Орхон аймгийн Соёл хяналтын улсын байцаагчтай хамтран Орхон аймгийн 9 Жаргалант сумын 2 объект хамрагдсан. Үүнд:<br>Соёл урлагийн газар<br>Музей<br>Нийтийн номын сан<br>Хүүхэд залуучуудын театр<br>Аялгуу соёлын төв<br>Баянцагаан соёлын төв<br>Баян-Өндөр хүүхэд залуучуудын соёлын төв<br>Хэмнэл соёлын төв<br>Эгшиглэн соёлын төв<br>Жаргалант сум Соёл мэдээллийн төв<br>Айрагийн гозгорын оршуулгын газар<br>Нийт 10 объект болон 1 улсын хамгаалалтад байх соёлын үл хөдлөх дурсгалт газарт хяналт шалгалтыг хийсэн. | 100 |
| 1.21.1.5 | Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системд зөрчилтэй бүртгэгдсэн иргэн, хуулийн этгээдийн газар эзэмшил, ашиглалтын байдалд урьдчилан сэргийлэх хяналт | Үйл ажиллагаа | Шалгалт хийсэн объектын тоо, илрүүлсэн зөрчил, арилгуулалтын хувь, улсын | - | Батлагдсан удирдамжийн хүрээнд хяналт шалгалтыг хийж илэрсэн зөрчлийг арилгуулсан байна.<br>Дүнг холбогдох хурлаар хэлэлцүүлэн, илэрсэн | Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын даргын 2024 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн 35-00/05 дугаар “Урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай” удирдамжийн дагуу Хяналт шалгалтыг түүврийн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | шалгалт хийж, зөрчлийг арилгуулах | | байцаагчийн гаргасан шийдвэрийн биелэлт, эрсдэлийн түвшин буурсан объектын тоо | | зөрчлийг бүрэн арилгуулах арга хэмжээг зохион байгуулсан байна.<br>Улсын байцаагчийн гаргасан шийдвэрийн биелэлтийг бүрэн хангуулсан байна. | арга ашиглан Баян-Өндөр сумын 475, Жаргалант сумын 155 нэгж талбар буюу аж ахуйн нэгж байгууллагын 128, иргэний 502 нэгж талбар нийт 630 нэгж талбарын газарт урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг хийсэн. Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системд зөрчилтэй бүртгэгдсэн нийт 230 нэгж талбарын зөрчлийг тухай бүр арилгаж ажилласан. | |
| 1.21.1.6 | Өмнөх хяналт шалгалтаар илэрсэн нэгж талбарын цахим системд үүсгэсэн хувийн хэргийн бүрдүүлэлтэд гүйцэтгэлийн хяналт хийх | Үйл ажиллаг аа | Шалгалт хийсэн объектын тоо, илрүүлсэн зөрчил, арилгуулалтын хувь, улсын байцаагчийн гаргасан шийдвэрийн биелэлт, эрсдэлийн түвшин буурсан объектын тоо | 2023 онд Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийн “Газрын кадастрын цахим систем”-д нэгж талбарын цахим хувийн хэргийн бүрдүүлэлтэд хяналт хийх, дүгнэлт гаргах, авах арга хэмжээний саналыг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдаж, удирдамжийн дагуу цахим системд үүсгэсэн хувийн хэргийн 1.2 хувь буюу 13,501 нэгж талбарын хувийн бүрдүүлэлтэд хяналт хийсэн. | **Эхний хагас жилд:**<br>Батлагдсан удирдамжийн хүрээнд хяналт шалгалтыг хийж илэрсэн зөрчлийг арилгуулсан байна.<br>дүнг холбогдох хурлаар хэлэлцүүлэн, илэрсэн зөрчлийг бүрэн арилгуулах арга хэмжээг зохион байгуулсан байна.<br>Улсын байцаагчийн гаргасан шийдвэрийн биелэлтийг бүрэн хангуулсан байна. | Өмнөх хяналт шалгалтаар илэрсэн нийт 45 нэгж талбарын цахим системд үүсгэсэн хувийн хэргийн бүрдүүлэлтэд гүйцэтгэлийн хяналт хийж илэрсэн зөрчлийг бүрэн арилгуулан ажилласан. | 100 |
| **Стратеги төлөвлөгөөний зорилго 1.22.<br>Хүн амын нутагшилт, суурьшлийн зохистой тогтолцоонд тулгуурлан хот байгуулалт, газрын харилцааны эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.** | | | | | | | |
| **1.22.2** | **Захиргааны чиглэлээр эрх зүйн актуудын хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх, боловсронгуй болгох** | **Үйл ажиллаг аа** | **Жил бүр 5-аас доошгүй эрх зүйн акт** | **Жил бүр 10 орчим эрх зүйн акт боловсруулж байна.** | **Нийт эрх зүйн актын 10 орчим хувийг шинэчилсэн байна.** | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.22.2.1 | Нийтээр болон салбарын хэмжээнд дагаж мөрдөх захиргааны хэм хэмжээний актын төсөлд санал өгөх | Үйл ажиллагаа | Санал өгсөн төслийн тоо | 2022 онд улсын хэмжээнд 6 норм, дүрэм, 5 стандарт, 12 журам, 3 зааварт санал өгсөн. | Нийтээр болон салбарын хэмжээнд дагаж мөрдөх захиргааны хэм хэмжээний актын төсөлд санал өгсөн байна. | Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилтийн бодит байдалд тулгарч буй хүндрэл, бэрхшээл, тулгамдаж буй асуудлыг сайжруулах талаар 16 асуулгын хүрээнд 2 төрлийн саналыг Орхон аймаг дахь ТАСЗ-д 2024 оны 124 дугаар албан бичгээр, Нэгж салбарын хувийн хэрэг хөтлөх журамд 2 төрлийн саналыг 2024 оны 204 дугаар албан бичгээр, Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журмын төсөлд 2 төрлийн санал өгч 2024 оны 91 дугаар албан бичгээр, газрын нэгдмэл сангийн удирдлагын цахим системийн хөгжүүлэлтэд 20 төрлийн саналыг 2024 оны 818 дугаар албан бичгээр тус тус ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн. | 100 |
| 1.22.2.2 | Эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг хэрэгжүүлэх, төлөвлөх ажлын хүрээнд газар, геодези, зураг зүйн хяналтын чиглэлээр эрсдэлийн шалгуур үзүүлэлтээр объектын эрсдэлийн үнэлгээ хийх | Үйл ажиллагаа | Эрсдэлийн үнэлгээг үнэлсэн байдал | 2023 онд улсын хэмжээнд 7035 объектод эрсдэлийн үнэлгээ хийсэн. | **Жилийн эцэст:** Эрсдэлийн шалгуур үзүүлэлтээр объектын эрсдэлийг үнэлэх ажлыг зохион байгуулсан байна. | Шилэн хяналтын цахим хуудсанд газар, геодези, зураг зүйн хяналтын чиглэлээр эрсдэлийн шалгуур үзүүлэлтээр тайлант онд 83 объектын эрсдэлийн үнэлгээг хийж ажилласан.барилгын хяналтын чиглэлээр төлөвлөгөөт шалгалт 15, урьдчилан сэргийлэх хяналт 41, эрсдлийн үнэлгээ хийсэн обект 100 барилга байгууламж үнэлгээ хийж шилэн хяналтад оруулсан байна | 100 |
| 1.22.2.3 | Их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн 2025 онд төлөвлөгөөт хяналт шалгалтад хамрагдах объектын жагсаалтыг батлуулах | Үйл ажиллагаа | Төлөвлөгөөт хяналт шалгалтад хамрагдах объектын жагсаалтыг батлуулсан байдал | Барилга, хот байгуулалтын Сайдын 2023 оны 74 дүгээр тушаалаар 2023 онд улсын хэмжээнд 367 объектод хяналт шалгалт хийсэн. | **Жилийн эцэст:** Төлөвлөгөөт хяналт шалгалтад хамрагдах объектын жагсаалтыг Засгийн газраар батлуулахад санал өгч, ГЗБГЗЗЕГ-тай хамтран ажилласан байна. | 2025 онд төлөвлөгөөт хяналт шалгалт хийх 10 объектын жагсаалтыг ГЗБГЗЗЕГ-ын салбарын хяналт шалгалтын хэлтсийн ахлах мэргэжилтэнд хүргүүлэн ажилласан. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| **1.22.5** | **“Тэрбум мод үндэсний хөдөлгөөн”-ий хүрээнд мод тарих ажлыг зохион байгуулах** | **Үйл ажиллагаа** | **Салбарын хэмжээнд 4761 мод** | **2021 онд ГЗБГЗЗГ, Нийслэлийн ГЗБА, 21 аймгийн ГХБХБГ нийт 3862 мод тарьсан.** | **“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тарих ажлыг зохион байгуулж, салбарын хэмжээнд тайланг нэгтгэн гаргасан байна.** | | |
| 1.22.5.1 | “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тарих ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | 110 ш мод | 2023 онд тус салбарын хэмжээнд хавар нийт 1886 мод тарьсанаас 1635 мод ургаж байна. | “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тарих ажлыг зохион байгуулж, тайланг ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна. | “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд хавар, намар мод тарилтыг зохион байгуулж 110 ширхэг агч мод тарьж, арчлалтыг хийж байна. | 100 |
| 1.22.5.2 | Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зориулалтаар газар эзэмшүүлэх байршлыг тодорхойлж газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөнд тусган хэрэгжилтийг хангуулах | Үйл ажиллагаа | Иргэн, аж хуйн нэгж, байгууллагад Мод ургуулгийн зориулалтаар олгосон газрын тоо, хэмжээ | - | Шинээр тарьж, арчилж ургуулсан ой, модоор бүрхэгдсэн болон тохижилт хийсэн цэцэрлэгт хүрээлэн, гудамжны талбайн хэмжээ нэмэгдсэн байна. | Жаргалант сумын 2024 он газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд нийтийн эзэмшил, ногоон байгууламж, цэцэрлэгжүүлж, зүлэгжүүлэх талбайн зориулалтаар 2 байршилд 0.47 га газрыг эзэмшүүлсэн.<br>2024 оны Байгаль хамгаалах арга хэмжээний зардлаар Баян-өндөр сум Зэст багийн нутаг дэвсгэр БОЭТөвийн ар талын 13 га талбайд ойн нөхөн сэргээлт хийж, мод тарих хавар, намрын ажлын хүрээнд Хүрэн булгийн аманд 3 га талбайд, Эрдэнэтийн Дулаан цахилгаан станцын үнсэн сан орчим 1 га талбайд, Шанд багийн овоот толгойд 4,7 га талбайд, Эрдэнэт хаалганы урд хэсэгт 5 га, Хангал голын голдирол дагуу 17 га талбайд, нийт 30.7 га талбайд 1.3 сая ширхэг мод шинээр тарьж, ойжуулалт,ойн төгөл, ойн зурвас байгууллаа. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| **1.22.6** | **“Бүсчилсэн хөгжлийг дэмжих жил”-ийн хүрээнд зохион байгуулсан арга хэмжээнд оролцох** | **Үйл ажиллагаа** | **Хэрэгжүүлсэн арга хэмжээ** | **Засгийн газрын 2023 оны 481 дүгээр тогтоолоор 2024 оныг “Бүсчилсэн хөгжлийг дэмжих жил” болгон зарласан.** | **“Бүсчилсэн хөгжлийг дэмжих жил”-ийн хүрээнд зохион байгуулсан арга хэмжээнд оролцсон байна.** | | |
| 1.22.6.1 | “Бүсчилсэн хөгжлийг дэмжих-Хариуцлагатай газрын харилцаа”-ны жилийн хүрээнд аймгийн хэмжээнд төлөвлөгөө гарган, хэрэгжүүлж ажиллах | Үйл ажиллагаа | Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо | ГЗБГЗЗЕГ-ын даргын 2024 оны А/05 дугаар тушаалаар 2024 оныг “Бүсчилсэн хөгжлийг дэмжих-Хариуцлагатай газрын харилцаа”-ны жил болгон зарласан. | Нэрэмжит жилийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан баталж, хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр ГЗБГЗЗЕГ-т тайлагнасан байна. | ГЗБГЗЗЕГ-ын даргын 2024 оны А/05 дугаар тушаалаар 2024 оныг “Бүсчилсэн хөгжлийг дэмжих-Хариуцлагатай газрын харилцаа”-ны жил болгон зарласантай холбогдуулан Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын даргын 2024 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн А/12 дугаар тушаалаар 9 хүний бүрэлдэхүүнтэй ажлыг хэсгийг байгуулж, салбарын хууль тогтоомжийг, иргэд олон нийтэд сурталчлах, газрын зөрчил маргаанаас урьдчилан сэргийлэх, хуулийн хэрэгжилтийг хангуулах, төрийн хяналт шалгалтыг иргэдэд ойлгомжтой болгох зэрэг нийт 39 арга хэмжээ зохион байгуулан ажиллаж тайланг 2024 оны 854 дугаар албан бичгээр ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн. | 100 |

**ХОЁР. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ**

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах нэгж |
|---|---|---|---|---|---|---|---|
| **2.1.2** | **Том масштабын байр зүйн тоон зураг, инженерийн шугам сүлжээний мэдээллийн** | **Үйл ажиллагаа** | **Байр зүйн тоон зураг, шугам сүлжээний мэдээллийн сангийн цахим** | **Байр зүйн тоон зураг, инженерийн шугам сүлжээний мэдээллийн санг** | **21 аймаг, нийслэлийн 1:1000-ны масштатбай байр зүйн болон инженерийн шугам сүлжээний зургийн** | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | **сангийн баяжуулалт, үйлчилгээ** | | **үйлчилгээгээр хэрэглэгч байгууллага, иргэдийг хангах** | **хөтлөх журам батлагдсан. Байр зүйн тоон зураг, шугам сүлжээний мэдээллийн санг цахимаар шинэчлэх боломж бүрдсэн.** | **мэдээллийн сангийн шинэчлэлтийг хөтөлсөн байна.** | | |
| 2.1.2.1 | Бусад байгууллагын захиалгаар хийгдсэн геодези, зураг зүйн ажлыг шалгаж хүлээн авах | Үйл ажиллагаа | Геодези, зураг зүйн ажлын үр дүн ирүүлсэн хүсэлтийн тоо | 2023 онд ААН-ийн ирүүлсэн хүсэлтэд хяналт хийж, дүгнэлтээр АМХ-д хүлээлгэн өгсөн. | Хүсэлт ирсэн тухай бүрд ажлыг шалгаж, үр дүнг хүлээн авч геопорталд мэдээллийг оруулж, хэрэглээнд гаргасан байна. | 2024 онд шинээр ашиглалтад орсон хүлээн авсан инженерийн шугам сүлжээний дэд бүтэц 29, тохижилтын 21, авто зам гүүрний 11, Шинээр баригдсан барилга байгууламж 9, Цахилгаан гэрэлтүүлгийн 15 ажлыг бүртгэн зургийн мэдээллийг Хот байгуулалтын мэдээллийн сангийн батлагдсан маягт болон жижүүрийн зураг хөтлөлтийн тайлангийн маягтын дагуу мэдээллийг бүрдүүлэн гүйцэтгэлийн зургийн хамт хүлээн авч жижүүрийн зургийн баяжилт хийсэн. | 100 |
| **2.1.3** | **Статик хэмжилтийн тэгшитгэн бодолтын онлайн боловсруулалтын системийн үйл ажиллагаа** | **Үйл ажиллагаа** | **1 систем** | **GNSS-ийн байнгын ажиллагаатай станцын сүлжээнд тулгуурлан статик хэмжилтийн тэгшитгэн бодолт хийдэг онлайн боловсруулалтын системийг хөгжүүлж, хэрэглээнд нэвтрүүлсэн.** | **GNSS-ийн байнгын ажиллагаатай станцын сүлжээнд тулгуурлан статик хэмжилтийн тэгшитгэн бодолт хийдэг онлайн боловсруулалтын системийн хэвийн ажиллагааг хангасан байна. Ази-Номхон далайн бүсийн геодезийн ажлын группд Монгол Улсын 6 GNSS-ийн байнгын ажиллагаатай станцын хэмжилтийн өгөгдлийг бэлтгэн илгээсэн байна.** | | |
| 2.1.3.1 | Геодезийн сүлжээний цэгийн солбицлыг ITRF2020 солбицлын | Үйл ажиллагаа | 1 цэг | Засгийн газрын 2022 оны 267 дугаар тогтоолоор ITRF2020 | **Эхний хагас жилд:** Аймгийн төвд байрлах гравиметрийн сүлжээний цэг | Байнгын ажиллагаатай ERDN-GNSS станцын бодит агшны 3-р улирлын хэмжилтийг 2024-09-26- | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | тогтолцоонд шилжүүлэх судалгаа хийх | | | солбицлын тогтолцоог ашиглахаар болсон. | дээр GNSS-ийн 12 цагийн хэмжилт хийж өгөгдлийг ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна. | ний өдөр Trimple R12 багажаар гравиметрийн сүлжээний GR200 цэг тэмдэгт дээр хийсэн тул дахин Аймгийн төвд байрлах гравиметрийн сүлжээний цэг дээр GNSS-ийн 12 цагийн хэмжилт, хийх шаардлагагүй гэсэн чиглэл ГЗБГЗЗЕГ-аас авсан. | |
| **2.1.4** | **Газар зүйн нэрийн мэдээллийн сангийн баяжуулалт, үйлчилгээ** | **Улсын болон орон нутгийн төсөв, үйл ажиллагаа** | **Монгол орны газар зүйн нэрийн мэдээллийн сан байгуулж, хэрэглээнд гаргах** | **1:100000-ны масштабтай байр зүйн зурагт орсон газар зүйн нэрийн мэдээллийн санг бий болгосон.**<br>**42 сумын газар зүйн нэрийн мэдээллийн санг цэг, шугам, талбайгаар үүсгэсэн.** | **Геопортал цахим системд 2020-2021 онд гүйцэтгэсэн газар зүйн нэрийн мэдээллийн санг хүлээн авч нэрийн мэдээллийн системд оруулсан байна.** | | |
| 2.1.4.1 | Газар зүйн нэрийн мэдээллийн сан хөтлөх | Үйл ажиллагаа | 1 мэдээллийн сан | 2021 онд Газар зүйн нэрийн мэдээллийн санг геопорталд оруулсан. | Геопортал цахим системд аймгийн хэмжээний газар зүйн нэрийн мэдээллийг засварлан оруулж, цахим үйлчилгээг нэвтрүүлсэн байна. | Орхон аймгийн Жаргалант сумын Газар зүйн нэрийн ажлыг Жаргалант сумын Засаг даргын Тамгын газартай “Эрд кадастр” ХХК нь 2024 оны 02 дугаар сарын 26-ны өдөр ОРАЖСЗДТГ/20240601003 дугаартай гэрээ байгуулан “Газар зүйн нэрийн хээрийн тодруулалт хийх” ажлыг 2024 оны 02 дугаар сарын 26-ны өдрөөс 2024 оны 09 дүгээр сарын 26-ны өдөр хүртэл хийж гүйцэтгэсэн. Жаргалант сумын Засаг даргын 2024 оны А/498 дугаар захирамжаар байгуулагдсан газар зүйн нэрийн зөвлөлөөр 2024 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр хэлэлцүүлж уг ажлын хүрээнд Улсын Их Хурлын 2003 оны 42 дугаар тогтоолоор баталсан 128, шинээр 13, орхигдсон 15, засварлах 1 нэр нийт 156 нэрийн тодруулалт хийгдсэн бөгөөд Жаргалант сумын | **100** |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар хэлэлцэн 2024 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн хүлээж авна. | |
| **2.1.5** | **Геодезийн байнгын цэг, тэмдэгтийн цахим санг шинэчлэх** | **Үйл ажиллагаа** | **GNSS-ийн дэд болон зураглалын сүлжээ 200 цэг, тэмдэг** | **Геодезийн цэг, тэмдэгтийн мэдээллийн санг шинэчилж, 2022 онд мэдээллийн санг цахимаар түгээх тогтолцоог бүрдүүлсэн.** | **Цэг, тэмдэгтийн цахим санг хөтөлж, шаардлагатай цэг, тэмдэгтийг нөхөн сэргээсэн байна.** | | |
| 2.1.5.1 | Геодезийн байнгын цэг, тэмдэгтийн цахим санг шинэчлэх | Үйл ажиллагаа | GNSS-ийн дэд болон зураглалын сүлжээний цэг, тэмдэгт | Геодезийн цэг, тэмдэгтийн мэдээллийн санг шинэчилж, 2023 онд мэдээллийн санг цахимаар түгээх тогтолцоог бүрдүүлсэн. | Бусад байгууллагын захиалгаар хийгдсэн геодезийн ажлын цэг, тэмдэгтийн мэдээллээр геодезийн цахим сангийн шинэчлэлтийг хөтөлсөн байна. | Жаргалант сумын урд хойд хорооллын дулааны шугам татах байр зүйн дэвсгэр зургийн ажлын хүрээнд “Од геодроект” ХХК компани J0102, J0304 дугаартай геодезийн цэгийг шинээр байгуулж хувийн хэрэг үүсгээд байна. “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГазрын “Үйлдвэр технологийн паркийн” байр зүйн зураглалын ажлын хүрээнд “Тэгш хэм групп” ХХК шинээр 33 цэг тэмдэгт, ДРОНИКС“ ХХК 16 цэг тэмдэгт, Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ийн шинэ хаягдлын сангийн 4300 га талбайн том масштабын геодезийн байр зүйн зураглалын ажлын хүрээнд хийгдсэн шинээр суулгасан геодезийн 28ш цэг тэмдэгтийг 2024 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр цэг тэмдэгтийг БД 11-104-19 стандартын дагуу 2024 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 02/24 дугаартай акт үйлдэн хүлээн авсан.Шинээр суулгасан цэгийг улсын нэгдсэн сан геопорталд бүртгүүлэх хүсэлт илгээгээд байна. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.1.5.2 | Геодезийн байнгын цэг, тэмдэгтийг хадгалах, хамгаалах, тооллого хийх, нөхөн сэргээх ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Нөхөн сэргээсэн цэгийн тоо | 2019 онд Газрын даргын А/291 дугаар тушаалаар “Геодезийн байнгын цэг, тэмдэгтийг хадгалах, хамгаалах, нүүлгэн шилжүүлэх” журмыг баталсан. | Цэг, тэмдэгт нөхөн сэргээсэн ажлын үр дүнг хүлээн авч, цэг, тэмдэгтийн мэдээллийг цахим санд оруулсан байна. | Аймгийн төвд байрлах Гравиметрийн GR200 цэг нь бүтээн байгуулалтын улмаас гэмтэж устаж болзошгүй тул хашаа хийж хамгаалсан. 2024 оны геодезийн сүлжээний цэгүүдэд үзлэг тооллого хийх ажлыг 10 сард зохион байгуулж Орхон аймгийн хэмжээнд геодезийн цэг тэмдэгтийн тооллогоор Тулгуур сүлжээн 1, Үндсэн 4, Дэд 11, Гравиметр 1, Триангуляци 6, Хадны марк 2, хөрсний репер 3, GPS 128, өндрийн 7 гэсэн 168 цэг тэмдэгтийн судалгааг гаргасан. Орхон аймаг, Баян-Өндөр сум, Баянцагаан багийн нутаг дэвсгэрт “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГазрын “Үйлдвэр технологийн паркийн” байр зүйн зураглалын ажлын хүрээнд “Тэгш хэм групп” ХХК шинээр 33 цэг тэмдэгт , ДРОНИКС“ ХХК 16 цэг Жаргалант сумын урд хойд хорооллын дулааны шугам татах байр зүйн дэвсгэр зургийн ажлын хүрээнд “Од геодпроект” ХХК 2 цэг тэмдэгт шинээр суулгаж улсын нэгдсэн сан геопорталд бүртгүүлэх хүсэлт илгээгээд байна. Тооллогын ажлын хүрээнд устсан 4 цэг, гэмтсэн 5 цэг бүртгэгдсэн ба 168 цэг, 7 тэмдэгтийн хувийн хэргийг хөтлөөд байна. Аймгийн хэмжээнд геопортал цахим системд геодезийн 116 цэг, тэмдэгт бүртгэлтэй байна. Баян-Өндөр сумын Уурхайчин багийн нутаг дэвсгэрт А1001 замтай холбосон авто замын засварын ажлыг гүйцэтгэх явцдаа ПП-006 дугаартай цэг, Хүрэнбулаг багийн нутаг дэвсгэрт газар шорооны ажлын | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | улмаас РР44-055 дугаартай цэг, Булаг багийн нутаг дэвсгэрт ПП62-003 дугаартай цэг, Жаргалант сумын Жаргалант багийн нутаг дэвсгэрт ПП6767 дугаартай цэгүүд устсан байх тул нөхөн сэргээх талаар тухайн цэг тэмдэгтийг устгасан аж ахуйн нэгжүүдэд мэдэгдэл хүргүүлсэн. | |
| **2.1.6** | **Хаягийн мэдээллийн системийг хөтлөх** | **Үйл ажилла гаа** | **Хаягийн мэдээллийн сангийн үйл ажиллагаа** | **Хаягийн мэдээллийн санг нэвтрүүлсэн.** | **Хаягийн мэдээллийн сангийн хэвийн үйл ажиллагааг хانган ажилласан байна.** | | |
| 2.1.6.1 | Нэр, хаяг олгогдоогүй гудамж, зам, талбайд нэр өгөх ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулж, ИТХ-ын тогтоолоор баталгаажуулсан гудамж, зам болон нэрэмжит болгосон талбайг мэдээллийн санд бүртгэх | Үйл ажиллаг аа | Гудамж, замын тоо | Хаягийн мэдээллийн систем | Нэр, хаяг олгогдоогүй гудамж, зам, талбайд нэр өгөх, нэрэмжит болгох ажлыг аймгийн ерөнхий архитектортай хамтран аймгийн хэмжээнд зохион байгуулж, ИТХ-ын тогтоолоор баталгаажуулж, нэр олгогдсон, нэрэмжит болгосон талбай, гудамж, замыг хаягийн мэдээллийн санд бүртгэсэн байна. | 2024 онд Төрийн худалдан авах ажиллагааны тухай хуулийн дагуу Гудамж талбайн нэр, эд хөрөнгийн хаягжуулалтын зургийг боловсруулж, хаягийн мэдээллийн нэгдсэн системд бүртгэлжүүлэх“ ажлыг Ланд Овнер” ХХК нь тендерт шалгарч гэрээ байгуулан ажил эхэлсэн. Хаягийн мэдээллийн систем дэх нэгж талбарын орц, гарц, зам, гудамжны эхлэл, төгсгөлийг зураглах ажлын хүрээнд аймгийн хэмжээнд хаягийн мэдээллийн систем дэх 1096 гудамжны эхлэл, төгсгөлийг зураглаж, нэр олгогдоогүй 68, шинээр нэр өгөх 6 гудамжны нэр өгөх ажил хийгдэж байна. Мөн кадастрын хаягийн мэдээллийн сангийн 25905 нэгж талбарт орц гарц зурагласан. Авто замыг зураглал хийхдээ мэдээллийн сан шинэчлэн 5051 атрибутан мэдээллийг бүрдүүлсэн. Тус ажлын хүрээнд нэр олгогдсон гудамж зам талбайн нэршилд замын мэдээлэлд баяжуулалт хийн | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | бүртгэсэн. Аймгийн хэмжээнд Засгийн газрын 2019 оны 325 дугаар тогтоолоор батлагдсан 21 гудамжны бүртгэл хийгдсэн. | |
| 2.1.6.2 | Кадастрын мэдээллийн санд бүртгэлтэй боловч хаяг олгогдоогүй нэгж талбарт Хаягийн мэдээллийн системээр хаяг олгож, баталгаажуулах, тус системийг үйл ажиллагаандаа тогтмол ашиглах | Үйл ажиллагаа | Гудамж, замын тоо | Хаягийн мэдээллийн систем | Хаяг олгогдоогүй нэгж талбаруудад хаяг олгож баталгаажуулсан байна | Кадастрын мэдээллийн санд бүртгэлтэй боловч хаяг олгогдоогүй, хаяг өөрчлөгдсөн 610 нэгж талбарт хаяг олгосон. | 100 |
| 2.1.6.3 | Хаягийн өгөгдөл мэдээллийг засварлах, шинэчлэн зураглах ажлын даалгаврын дагуу Хаягийн мэдээллийн систем дэх алдаатай өгөгдөл мэдээг засварлах | Үйл ажиллагаа | Зам, гудамж, орц гарц, гудамжны эхлэл, төгсгөлийн тоо | Хаягийн мэдээллийн систем | **Жилийн эцэст:** Батлагдсан ажлын даалгаврын дагуу Хаягийн мэдээллийн систем дэх алдаатай өгөгдөл мэдээллийг засварласан байна. | Гудамж талбайн нэр, эд хөрөнгийн хаягжуулалтын зургийг боловсруулж, хаягийн мэдээллийн нэгдсэн системд бүртгэлжүүлэх“ ажлыг Ланд Овнер” ХХК нь тендерт шалгарч гэрээ байгуулан ажил эхэлсэн. Хаягийн мэдээллийн систем дэх нэгж талбарын орц, гарц, зам, гудамжны эхлэл, төгсгөлийг зураглах ажлын хүрээнд аймгийн хэмжээнд хаягийн мэдээллийн систем дэх 1096 гудамжны эхлэл, төгсгөлийг зураглаж, нэр олгогдоогүй 68, шинээр нэр өгөх 6 гудамжны нэр өгөх ажил хийгдэж байна. Мөн кадастрын хаягийн мэдээллийн сангийн 25905 нэгж талбарт орц гарц зурагласан. Авто замыг зураглал хийхдээ мэдээллийн сан шинэчлэн 5051 атрибутан мэдээллийг бүрдүүлсэн. Тус ажлын хүрээнд нэр олгогдсон | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | гудамж зам талбайн нэршилд замын мэдээлэлд баяжуулалт хийн бүртгэсэн. Аймгийн хэмжээнд Засгийн газрын 2019 оны 325 дугаар тогтоолоор батлагдсан 21 гудамжийн бүртгэл хийгдсэн. | |
| 2.1.7 | **Газрын үнэлгээ, төлбөр, татвар, газрын биржтэй холбоотой үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, хяналт тавих** | **Үйл ажиллагаа, ургалт төсөв** | **Нийслэл, 21 аймаг** | **Газрын үнэлгээ, төлбөр, татвар, газрын биржийн системийг нэвтрүүлсэн.** | **Газрын үнэлгээ, төлбөр, татвар, газрын биржтэй холбоотой үйл ажиллагаанд хяналт тавьж, мэргэжил арга зүйгээр хангаж ажилласан байна.** | | |
| 2.1.7.1 | Газрын төлбөр, татварын ногдуулалтыг Татварын удирдлагын нэгдсэн системд илгээх, уг системээс газрын төлбөр, татварын төлөлтийн мэдээллийг хүлээх авах ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Татварын удирдлагын нэгдсэн системд илгээсэн, системээс төлөлтийн мэдээлэл хүлээн авсан нэгж талбарын тоо | Газрын төлбөр, татварын систем | Хуульд заасан хугацаанд төлбөр, татварын ногдуулалтыг илгээх, төлөлтийн мэдээллийг тухай бүр хүлээж авсан байна. | Газрын кадастрын программ хангамжид бүртгэгдсэн Баян-Өндөр сумын 5958 нэгж талбарт 26962,0 сая төгрөгийн ногдуулалт хийж 7052 нэхэмжлэх, Жаргалант сумын 1146 нэгж талбарт 130,69 сая төгрөгийн ногдуулалт хийж 1187 нэхэмжлэхийг тус тус үүсгэн татварын нэгдсэн системд илгээгээд байна.<br>Тайлант онд орон нутгийн төсөвт газрын төлбөрийн орлогоос 27300,0 сая төгрөг төвлөрүүлэх төлөвлөгөө батлагдсан ба газрын төлбөрийн орлого хүлээгдэж буй гүйцэтгэлээр 27111,0 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн. Газрын үл хөдлөх эд хөрөнгийн татвар ногдуулах ажлын хүрээнд 2024 онд аймгийн хэмжээнд 17470 нэгж талбарт газрын татварын бодолтыг хийж, үүнээс Баян-Өндөр суманд 16962 иргэнд 39,3 сая төгрөг, Жаргалант суманд 508 иргэнд 150 мянган төгрөгийн ногдуулалт хийж нэхэмжлэх үүсгэлээ. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.1.7.2 | Төлбөрийн даалгавар үүсгэн тэмдэгтийн хураамж, хураамжийн ногдуулалтыг хийж Татварын удирдлагын нэгдсэн системд илгээх ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Эрхийн харилцаанд орж байгаа нэгж талбарын тоо | Газрын төлбөр, татварын систем | Үйлчилгээ үзүүлсэн тоогоор тэмдэгтийн хураамж, үйлчилгээний хураамжийн төлбөрийн даалгавар үүсгэсэн байна. | 2024 онд улсын тэмдэгтийн хураамжийн 12,834,000 төгрөгний 1298 нэхэмжлэлийг татварын удирдлагын нэгдсэн системд илгээж 12,834,000 төгрөгийг тэмдэгтийн хураамжийн орлогоос оруулаад байна.<br>Үүнээс Баян-Өндөр сумын 1033 нэгж талбарт 10,778,000 төгрөгний ногдуулалт хийж 10,778,000 төгрөгний орлого, Жаргалант сумын 265 нэгж талбарт 2,056,000 төгрөгний ногдуулалт хийж 2,056,000 төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн байна. | 100 |
| 2.1.7.3 | Газрын төлбөр, татвар, тэмдэгтийн хураамж, үйлчилгээний хураамжийг цахимаар төлөлт хийх бүх боломжуудын талаар иргэд, олон нийтэд сурталчлах | Үйл ажиллагаа | Цахим системийн хэрэглээ | Газрын төлбөр, татварын систем | **Эхний хагас жилд:**<br>Газрын төлбөр, татвар, тэмдэгтийн хураамж, үйлчилгээний хураамжийг цахимаар төлөх боломжийг сурталчилсан байна. | Иргэн, аж ахуйн нэгж байгууллагад газрын дуудлага худалдаанд хэрхэн оролцох, тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан газрын мэдээлэл авах, газрын төлбөрийг газрын төлбөр татварын систем рүү орж харах, гар утасны апплекейшн болон бусад цахим хэлбэрийг ашиглан газрын төлбөрийг төлөх талаар байнга сурталчлах ажлыг зохион байгуулж байна. Дээрх мэдээллийг:<br>Газрын удирдлагын нэгдсэн сангийн www.egazar.gov.mn сайт,<br>●Байгууллагын www.erdenet.gazar.gov.mn сайт<br>●Газрын биржийн цахим систем www.mle.mn сайт<br>●“Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар” фейсбүүк хуудсаар дамжуулан иргэд, олон нийтэд ил тод нээлттэй хүргэж байна. | 100 |
| 2.1.7.4 | Газрын зах зээлийн үнийн мэдээллийг Газрын үнэлгээний системд | Үйл ажиллагаа | Газрын зах зээлийн үнийн мэдээллийн тоо | Газрын үнэлгээний систем | **Эхний хагас жилд:** | Газрын биржийн www.mle.mn цахим программ хангамжид бүртгэгдсэн газар, үл хөдлөх | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | оруулах, масс үнэлгээ хийх | | | | Хот, тосгон, бусад суурин газрын зах зээлийн үнийн мэдээллийг оруулсан байна.<br>**Жилийн эцэст:**<br>Бүртгэсэн зах зээлийн үнийн мэдээллийг ашиглан масс үнэлгээ хийсэн байна. | хөрөнгийн зах зээлийн үнийн мэдээг Газрын үнэлгээний системд оруулах ажлыг хийлээ. 2024 онд 806 нэгж талбарын үнийг хөрвүүлж, эдийн засгийн үнэлгээ хийхэд ашиглаж байна. | |
| 2.1.7.5 | Иргэн, хуулийн этгээдэд олгогдсон газарт дуудлага худалдааны үнэ, дуудлага худалдааны анхны үнэ төлсөн болон нөхөх олговроор олгосон, чөлөөлсөн талаарх өгөгдөл мэдээллийг цуглуулан боловсруулалт хийж, мэдээллийн сан үүсгэх; | Үйл ажиллаг аа | Газрын зах зээлийн үнийн мэдээллийн тоо | Газрын үнэлгээний систем | **Эхний хагас жилд:**<br>Иргэн, хуулийн этгээдэд олгогдсон газарт дуудлага худалдааны үнэ, дуудлага худалдааны анхны үнэ төлсөн болон нөхөх олговроор олгосон, чөлөөлсөн талаарх өгөгдөл мэдээллийг цуглуулан боловсруулалт хийж, мэдээллийн сан үүсгэж, ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна. | ГЗБГЗЗЕГ-т Газрын үнэлгээ болон газрын төлбөр, татварын цахим системийн нэмэлт хөгжүүлэлтийн ажил хийгдэх гэж байгаатай холбогдуулан 2003 оноос хойш мөрдөж байсан үнэлгээний бүс тогтоосон Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тогтоол, үнэлгээний бүсийн хил зааг (тоон хэлбэр /*.shp/)-ийн зургийг гаргаж 2024 оны 277 тоот албан бичгээр албан бичгээр хүргүүлсэн. | 100 |
| 2.1.7.6 | Газрын биржийн цахим системээр газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн дуудлага худалдаа, газар эзэмших, ашиглах эрхийн төсөл сонгон шалгаруулалт зохион байгуулах | Үйл ажиллаг аа | Тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан нэгж талбарын тоо | Газрын биржийн цахим системээр зохион байгуулах боломж бүрдсэн. | Тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан газарт дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалт зохион байгуулсан байна. | Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 17/03 дугаар тогтоолоор батлагдсан "Газрын харилцааны талаар 2024 онд баримтлах үйл ажиллагааны чиглэл”-д тусгагдсан Баян-Өндөр сумын 11 байршилд 3,59 га, Жаргалант сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 09 дүгээр тогтоолоор батлагдсан Газар зохион байгуулалтын 2024 оны төлөвлөгөөний дагуу Жаргалант сумын 4 байршилд 0,11 га газарт газар ашиглах, эзэмших эрхийн гэрчилгээний дуудлага худалдааг зохион байгуулахаар төлөвлөсөн.<br>Аймгийн ИТХ-ын тогтоолын дагуу 10 байршил 2,43 га газарт 3 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | удаагийн цахим дуудлага худалдааг зохион байгуулсан. Үүнээс 8 байршилд 1.41 га газрыг худалдаж дуудлага худалдааны орлогоос 804,493,000 төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн.<br>Жаргалант сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу 4 байршил 0.11 га газарт танхимын дуудлага худалдааг зохион байгуулж 3,362,400 төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн.<br>Жаргалант суманд газар зохион байгуулалтын төлөвлөгөөний тодотголоор хөдөө аж ахуйн зориулалтаар 8 байршилд 18,72 га газрыг төлөвлөн батлагдсаны дагуу газрын цахим биржээр төсөл сонгон шалгаруулалтыг нээлттэй зохион байгуулсан.<br>Үүнээс 5 малчдын хоршооноос төслийн материал ирүүлснээс 3 байршилд төсөл шалгарч 11 га газрыг сумын Засаг даргын захирамжаар эзэмшүүлсэн. | |
| 2.1.7.7 | Газрын биржийн цахим програм хангамжаар дамжуулан газар, үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үнийн мэдээ цуглуулах, олон нийтэд үйлчлэх | Үйл ажиллагаа | Эрх шилжсэн нэгж талбарын тоогоор үнийн мэдээ нэмж бүртгэнэ. | Газрын биржийн цахим системд газар, үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үнийн мэдээ бүртгэх боломжтой болсон. | Газрын эрх шилжсэн нэгж талбарын тоогоор газар, үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үнийн мэдээг Газрын биржийн цахим системд бүртгэсэн байна. | Газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхээ шилжүүлсэн 806 нэгж талбарын үнийн мэдээг Газрын биржийн www.mle.mn цахим программд бүртгээд байна. | 100 |
| **2.1.8** | **Газрын кадастрын мэдээллийн сангийн үйл ажиллагааг удирдан** | **Үйл ажиллагаа** | **Газрын кадастрын мэдээллийн** | **Газрын кадастрын мэдээллийн санг нэвтрүүлсэн.** | **Газрын кадастрын мэдээллийн санг удирдан зохион байгуулж,** | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | **зохион байгуулах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, хяналт тавих** | | **сангийн үйл ажиллагаа** | | **мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч үйл ажиллагаанд хяналт тавьж ажилласан байна.** | | |
| 2.1.8.1 | Сумдын газрын даамлуудын өмнөх онуудад үүсгэсэн нэгж талбарын хувийн хэрэгт хяналт шалгалт хийж, илэрсэн алдаа дутагдалыг арилгах, сайжруулах, нөхөн бүрдүүлэх, цэгцлэх, ажлыг зохион байгуулах | Үйл ажиллаг аа | Засвардлагдсан нэгж талбарын хувийн хэргийн тоо | Нэгж талбарын хувийн хэргийн тоо | Нэгж талбарын хувийн хэрэгт холбогдох журмын дагуу хяналт хийгдэж алдаа, дутагдал заварлагдаж, авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх тайланг ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна. | Газрын даргын 2024 оны А/120 тоот тушаалаар Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийн газрын кадастрын цахим системд нэгж талбарын цахим хувийн хэргийн бүрдүүлэлтэд хяналт хийж, дүгнэлт гарган, авах арга хэмжээний саналыг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулан аймгийн хэмжээнд түүвэрлэн 200 нэгж талбарын хувийн хэрэгт хяналт шалгалтын ажлыг зохион байгуулсан.<br>Мөн тайлант онд 2 сумын 2003 оноос хойш гарсан эрх бүхий этгээдийн шийдвэр хяналт хийх ажлын хүрээнд аймгийн хэмжээнд нийт 3300 нэгж талбарын хувийн хэрэгт авагдсан баримт бичгийг ГКМС-ийн мэдээлэл болон цахим баримт бичигтэй тулган буруу бүртгэсэн болон буруу оруулсан мэдээлэл, баримт бичгийн зөрчлийг арилгах ажлыг хийж гүйцэтгэсэн. | 100 |
| 2.1.8.2 | Газрын кадастрын мэдээллийн системд бүртгэгдсэн цахим архивын материалд хяналт шалгалт хийж, илэрсэн алдаа дутагдалыг арилгах, сайжруулах, нэгж талбарын хувийн хэргийн | Үйл ажиллаг аа | Засварлаж сайжруулсан цахим хавсралтын тоо | Системд бүртгэгдсэн өргөдлийн тоо | ГКМС-ийн өргөдлийн цахим хавсралтад хяналт шалгалт хийгдэж алдаа дутагдал засварлагдаж, хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх тайланг ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна. | ГЗБГЗЗЕГ-аас 2023 оны 1/2332 дугаар арга хэмжээ авах тухай албан бичгийн дагуу Газрын кадастрын мэдээллийн санд бүртгэлтэй өргөдөлд хавсаргасан баримт бичигт хийсэн хяналтын | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | бүрдлийн дагуу цахим хавсралтыг баяжуулах арга хэмжээг зохион байгуулах | | | | | дүнгээр илэрсэн зөрчлийн дагуу дутуу бүрдүүлсэн 30, бөөндөж сканердаж оруулсан 18, буруу материал оруулсан 10 баримт бичгийг нэгж талбарын хувийн хэрийн баримт бичигтэй тулган ГКМС-д хавсаргах баримт бичгийг хавсарган алдаа дутагдлыг арилгасан.<br>Харин хоосон цаас оруулсан гэх зөрчил нь Орхон аймгийн хэмжээнд иргэн, хуулийн этгээдийн газрыг баталгажуулахад хуучин мэдээллийн санд бүртгэлтэй мэдээллээс ГКМС-д унагах зарчмаар баталгаажуулах үйл ажиллагааны явцад баримт бичиг татагдаагүй зөрчлүүд байна. Энэ асуудлыг шийдвэрлэж өгөх тухай хүсэлтийг ГЗБГЗЗЕГ-т гарган ажилласан<br>Түүнчлэн урд онуудад бүртгэгдсэн 2150 өргөдлийн хавсралт материалыг баяжуулан засварлаад байна. | |
| 2.1.8.3 | Газрын нэгдсэн цахим систем egazar.gov.mn-ийн үйл ажиллагааг иргэд олон нийтэд сурталчилах, танилцуулах аргах хэмжээг зохион байгуулах, орон нутагт цахим үйлчилгээний хэрэглээг нэмэгдүүлэх | Үйл ажиллаг аа | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | Газрын нэгдсэн цахим систем /egazar.gov.mn/ | Цахим системийн хэрэглээ нэмэгдэж иргэд олон нийт Egazar.gov.mn хаягаас газартай холбоотой мэдээ, мэдээлал авах, цахимаар хүсэлт илгээдэг болж цахимаар илгээх хүсэлтийн тоог нэмэгдүүлсэн байна | Газрын нэгдсэн цахим систем egazar.gov.mn-ийн үйл ажиллагааг иргэд олон нийтэд сурталчлах, танилцуулах арга хэмжээг 2024.02.20-2024.02-21-ний өдөр Баян-өндөр сумын Чандмань баг, Найрамдал багт нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулж нийт 300 орчим иргэнд газрын цахим системийг сурталчлан ажилласан. Мөн 2024.05.26-нд Орхон аймгийн ЗДТГ-аас зохион байгуулсан нээлттэй хаалганы өдөрлөгөөр иргэдэд Газрын нэгдсэн цахим систем egazar.gov.mn-ийн үйл ажиллагааг сурталчилж 300 гаруй | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | иргэнд www.egazar.gov.mn сайтаар дамжуулан газартай холбоотой үйлчилгээг хэрхэн авах мөн шинээр төрөөс үнэ төлбөргүй газар эзэмших хүсэлт илгээх заавар мэдээллийг хүргэж 200 гаруй гарын авлага материал тараасан. Байгууллагын www.erdenet.gazar.gov.,mn цахим хуудас болон www.facebook.com/erdenetgazar фэйж хуудсанд egazar цахим системд иргэн аж ахуйн нэгж тоон гарын үсгээр хэрхэн нэвтрэх цахим хүсэлт илгээх зааврыг байршуулан иргэд олон нийтэд мэдээлэл хүргэн ажиллаж байна. Цахимаар илгээсэн хүсэлтийн хүсэлтийн тоо өмнөх онд 2800 байсан бол энэ онд 6093 хүсэлт хүлээн авч өмнөх оноос 2,5 дахин өссөн байна. | |
| 2.1.8.4 | Иргэн, хуулийн этгээдээс ирүүлж буй хүсэлтүүдийг цахим системээр дамжуулан хүлээн авч, шийдвэрлэх ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Шийдвэрлэгдсэн хүсэлтийн тоо | Газрын кадастрын мэдээллийн санд нийт бүртгэсэн өргөдөл | Иргэн, хуулийн этгээдээс ирүүлж буй хүсэлтүүдийг цахим системээр дамжуулан хүлээн авч, шийдвэрлэх ажлыг зохион байгуулсан байна. | Газрын кадастрын цахим системээр нийт 6093 иргэн хуулийн этгээдийн хүсэлт ирснээс шийдвэрлэсэн 961, өргөдөл үүсэж судалж байгаа 848, шинээр ирсэн 48, буцаагдсан 1862, хугацаа хэтэрсэн (шинээр газар хүссэн) 2374 хүсэлт байна. | 100 |
| 2.1.8.5 | Нийт сумдын 2003 оноос хойш гарсан эрх бүхий этгээдийн шийдвэр тус бүрт хяналт хийж ГКМС-д бүртгэгдээгүй иргэн, хуулийн этгээдийн судалгааг гарган нөхөн бүрдүүлэх арга хэмжээг эцэслэн дуусгах | Үйл ажиллагаа | Захирамжийн тоо, нөхөн бүртгэж оруулсан нэгж талбарын тоо | Газрын кадастрын мэдээллийн санд бүртгэгдээгүй нэгж талбарын тоо | Эрх бүхий этгээдийн шийдвэр тус бүрт хяналт хийж ГКМС-д бүртгэгдээгүй иргэн, хуулийн этгээдийн судалгааг гаргасан байна. ГКМС-д нөхөн бүртгэх арга хэмжээ бүрэн дууссан байна. | Аймгийн хэмжээнд газрын нэгдсэн удирдлагын цахим системд ороогүй газар эзэмших, өмчлөх бүртгэлийг баг бүрд зохион байгуулж газрын кадастрын мэдээллийн санд бүртгэгдээгүй 2900 нэгж талбарыг нөхөн бүртгэж газрын кадастрын мэдээллийн санд бүртгээд байна. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.1.8.6 | Киоски төхөөрөмжийг хүртээмжийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулж газартай холбоотой үйлчилгээг иргэд олон нийтэд нэг цэгээс түргэн шуурхай хүргэх боломжийг бүрдүүлэх | Орон нутгийн төсөв | Аймаг, сумдад шинээр нэвтрүүлсэн төхөөрөмжийн тоо | Улсын хэмжээнд 2022 оноос эхлэн нийт 21 төхөөрөмжийг нэвтрүүлсэн. | Киоски төхөөрөмжийг хүртээмж нэмэгдэж газартай холбоотой үйлчилгээг иргэд олон нийт нэг цэгээс түргэн шуурхай авах боломж бүрдсэн байна. | Газрын харилцааны egazar цахим системийг хүртээмжийг нэмэгдүүлэх газартай холбоотой үйлчилгээг иргэд олон нийт нэг цэгээс түргэн шуурхай авах зорилгоор аймгийн аймгийн хэмжээнд 2 төхөөрөмж байршуулан үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна. 2025 онд 1 киоск төхөөрөмж нэмж авахаар орон нутгийн төсөвт тусгаад байна. | 100 |
| 2.1.8.7 | Киоски төхөөрөмжөөс иргэд олон нийтэд үзүүлж буй газартай холбоотой үйлчилгээнээс төлбөр тооцох боломжийг бүрдүүлж холбогдох байгууллагатай гэрээ байгуулж ажиллах | Үйл ажиллаг а | Холбогдох байгууллагатай хийсэн гэрээ | 2023 онд төлбөр тооцох хөгжүүлэлтийг гүйцэтгсэн. | Холбогдох байгууллагатай гэрээ байгуулж Киоски төхөөрөмжөөс иргэд олон нийтэд үзүүлж буй газартай холбоотой үйлчилгээ төлбөртэй болсон байна. | Архивын ерөнхий газрын даргын 2023 оны А/68 дугаар тушаалын дагуу Газрын удирдлагын нэгдсэн цахим системээс архивын мэдээллээр үзүүлэх 13 үйлчилгээний хөлсний хэмжээг баталсан. Газрын удирдлагын Egazar.gov.mn цахим систем болон киоск төхөөрөмжөөр газартай холбоотой үйлчилгээг иргэд, аж ахуйн нэгж байгууллагууд банкны апплейкшн ашиглан хялбараар төлбөр төлөх боломжийг бүрдүүлэх үүднээс 2024 оны 01 сард ”ККТТ” ХХК -тай гэрээ байгуулсан. Үүний дагуу киоск төхөөрөмж QPAY ашиглан 12,493,320 төгрөгийн орлогыг төвлөрүүлээд байна. | 100 |
| 2.1.8.8 | Газрын кадастрын мэдээллийн сангийн өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хангаН ажиллах, өгөгдөл, мэдээлэл, цахим хавсралтыг үнэн зөв бүрдүүлж ажиллах | Үйл ажиллаг аа | Системийн хэвийн үйл ажиллагаа | Газрын кадастрын мэдээллийн систем | ГКМС-ийг холбогдох журам, зааврын дагуу өгөгдөл мэдээллийг үнэн зөв бүртгэж өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хангаж ажилласан байна. | Газрын кадастрын мэдээллийн сангийн өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хангаН ашиглаж байна. Тайлант онд цахим системээр 1089 иргэн хуулийн этгээдийн цахим өргөдлийг хүлээн авч цахим хувийн хэргийн бүрдлийг шалган өргөдөл үүсгэж шийдвэрлэсэн. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.1.8.9 | ГКМС-д бүртгэгдсэн орон нутгийн тусгай хэрэгцээний газрын давхаргад хяналт шалгалт хийж буруу, зөрүүтэй бүртгэгдсэн мэдээллийг эрх бүхий этгээдийн шийдвэрт үндэслэн засварлах, сайжруулах, шинээр ОНТХ-нд авсан газрыг бүртгэж баталгаажуулах | Үйл ажиллагаа | Орон нутгийн тусгай хэрэгцээнд авсан газрын тоо | - | **Жилийн эцэст:** Аймаг, сумдын хэмжээнд ОНТХ-нд авсан эрх бүхий этгээдийн шийдвэрийн судалгааг гаргаж ГКМС-д бүртгэгдсэн мэдээлэлд нэг бүрчлэн хяналт хийж, илэрсэн алдаа дутагдлыг засварласан байна. Шинээр авсан газрыг кадастрын нэгдсэн системд бүртгэж, баталгаажуулсан байна. | АИТХ-ын 2017 оны 01 дүгээр тогтоолоор Баян-Өндөр уулын 1702.01 га газар, 2017 оны 137 дугаар тогтоолоор 18 байршилд 111 булш, хиргисүүрийн 11.3 газрыг орон нутгийн тусгай хэрэгцээнд авсан бөгөөд эдгээр газруудыг газрын кадастрын мэдээллийн санд бүртгэж оруулаад байна.<br>АИТХ-ын 2024 оны 19/02 дугаар тогтоолоор 8 байршилд булш, хиргисүүрийн орон нутгийн тусгай хэрэгцээнд хамгаалалтад аваад байна. | 100 |
